эрэмбэтэй урт шугамлаг хэсгүүд, (iii) хөндлөн огтлолын шугаман хэмжээ нь хэдэн зуун нанометрээс микрометрийн эрэмбэтэй байх аварга хэмжээтэй томоохон бүхэл хэсгүүд гэсэн гурван үндсэн хэсгийг агуулж байгаа нь ажиглагддаг.

Ургасан хэсгийн дотор байгаа эдгээр жижиг хэсгүүдэд хийсэн EDX анализын дүнгээс үзэхэд олонхи нь дан ганц нүүрстөрөгч элементээс тогтоно. Энд төлөөлөл болгон Зураг 6-д үзүүлсэн тахир шугаман хэсгийн хувьд хийсэн EDX анализын дүнг үзүүлээ (Хүснэгт 2).




Зураг 6. Ниргэлгийн явцад ургаж томорсон катодын материалын доторхи нэг шугамлаг бүтцийн EDX-ийг авсан цэгүүд.

Энэ шугаман хэсгийн уртын дагуух янз бүрийн цэгт хийсэн анализын дүн энэ бүтэц бүхэлдээ дан нүүрстөрөгчөөс тогтож байгааг харуулдаг.

Хүснэгт 2. Шугаман элементэд хийсэн EDX анализ.

	Elt.	Line	Intensity, (c/s)	Atomic, %
a	C	Ka	639.44	100.000
б	C	Ka	692.22	100.000
в	C	Ka	598.34	100.000

Үүний зэрэгцээ бусад хэсгүүд дээр хийсэн анализын дүн ч эдгээр нь дан нүүрстөрөгчөөс тогтож байгааг харуулдаг. Харин энэ дүгнэлтээс гажих нэг тохиолдлыг Зураг 7-т үзүүлэв. Энэ нь аварга хэмжээтэй бөөмцөр дээр ажиглагддаг. Энд хүчилтөрөгчийн атомд харгалзах спектр ажиглагдах ба уг бөөмцөрийн доторхи хүчилтөрөгчийн атомын эзлэх хувь 1.5%-аас хэтэрдэггүй. Энэ нь өндөр температурын үйлчлэлээр явагдах усны молекулын диссоциацаар үүссэн хүчилтөрөгчийн атомуудын мөр төдий зүйл байх боломжтой юм.




Зураг 7. Ургасан материалын дотор ажиглагдах аварга хэсгийн тэмдэглэсэн цэг дээр ажиглагдах хүчилтөрөгчийн атомын спектр.

Одоо катод дээр ургасан бүтцийн дотор агуулагдах үндсэн хэсгүүдийг тус бүрд нь нарийвчлан авч үзье.

1) Ийм жижиг хэсгүүдийн онцлог нь бусад бүрдүүлэгч хэсгүүдтэй харьцуулахад дангаараа оршин байх нь элбэг бөгөөд хэмжээний хувьд 50-100 нм-ээс ихгүй шугаман хэмжээтэй, бөмбөрцөгт ойр хэлбэртэй байдаг. Дээжийн дотор тааралдах хамгийн жижиг элементийн шугаман хэмжээ 10 нм, харин дангаар орших хамгийн томынх шугаман хэмжээ 90-100 нм хүрдэг. Эдгээр нь макро хэсгүүд дээр олонтаа тааралдах боловч түүний макро хэсэгтэй холбоотой, эсвэл түүнээс ургасан эсэхийг энэ судалгааны хүрээнд тодорхойлох боломжгүй байна.

2) Шугамлаг хэсгүүд нь хэмжээгээрээ харилцан адилгүй боловч хэлбэрийн хувьд гонзгой буюу сунасан, бараг шугаман бүтэц байдаг. Үүний зэрэгцээ эдгээр бүтэц нэг үзүүрээрээ эсвэл хоёр үзүүрээрээ заавал өөр нэг элементтэй холбогдсон байдаг. Эдгээр элементүүд олонхи тохиолдолд макро болон жижиг хэсгүүдээс урган гарсан байх ба хэмжээ нь уртассан үедээ нөгөө үзүүрээрээ эсвэл дундуураа өөр хэсэгтэй холбогдсон байдаг (Зураг 8а,в). Мөн богино хэмжээтэй ийм хэсгүүд харьцангуй өргөн диаметртэй бөгөөд үзүүр хэсэг рүүгээ үргэлж нарийссан байдаг (Зураг 8б). Эдгээр нь нэг жижиг хэсгээс олон салаалж ургасан байх нь ч бий. Диаметрийн хувьд 20 нм-ээс хэтэрдэггүй, харин ажиглагдах хамгийн бага диаметр 10 нм-ээс бага байна. Уртын хувьд хэдэн арван нм-ээс эхлээд микрометр хүртэл урттай ч тааралддаг. Эдгээр шугаман хэсгүүдийг нарийвчлан харахад зарим нь хөндий, зарим бараг цул байдаг. Ийм учраас эдгээр нь нанохоолой, нано утас юм. Үүнийг эдгээрийн хөндлөн огтлолыг судлах замаар нарийвчлан шалгаж болно. Нано хоолойн хананы зузаан янз бүр бөгөөд SEM зургийг үндэслэн ойролцоогоор түүний диаметрийн гуравны хоёроос аравны нэгийн хооронд утгатай байгаа гэсэн дүгнэлт гаргаж болно.



Зураг 8. а) нэг жижиг хэсгээс ургасан шугаман хэсэг, б) ургасан хэсгийн доторхи богино, харьцангуй өргөн диаметртэй жижиг хэсгүүдийн үзүүрлүүгээ нарийссан байдал (Энэ зургийн дотор урган уртасч байгаа жижиг

хэсгүүд олныг харж болно), в) аварга том хэсэг дээр ургасан шугамлаг хэсэг.

3) Макро буюу хөндлөн огтлолын шугаман хэмжээ нь хэдэн зуун нанометрээс микрометрийн эрэмбэтэй байх томоохон бүхэл хэсгүүд нь тухайн эзлэхүүний дотор цөөн тоотой тааралдах боловч эзлэхүүний хэмжээ ихтэй учраас дээжийн эзлэхүүний багагүй хэсгийг эзэлнэ. Эдгээрээс зарим тохиолдолд шугаман элементүүд урган гарсан байдаг.

Эдгээр бүтцүүдийн эзлэх хувь хэмжээ, агууламжийн харьцааг тодорхойлох асуудлыг авч үзье. Хэрэв бид энэ дээжийг нэгэн төрөл гэж үзвэл хэвтээ хавтгайн дагуу ажиглагдаж байгаа энэ дүр зураг гүний дагууд ч бас ажиглагдах ёстой. Ажиглагдаж байгаа дүрсийн тодорхой талбайтай хэсгийг сонгон авч энэ талбай дотор ажиглагдах бүтцийг тоолъё. Сонгон авсан талбайг дүрсийн фокусын гүнээр үржүүлэн эдгээр бүтцүүд оршин байгаа мужийн эзлэхүүнийг олно. SEM дүрсийн фокусын буюу

харааны талбайн гүнийг $d = \frac{4 \cdot 10^2 W}{A M}$ (W -дээж ба линзийн хоорондох ажлын зай, A -апературын диаметр M -өсгөлт) томъёогоор илэрхийлж болно. Энэ эзлэхүүн дотор орших тухайн нэг бүтцийн тоог эзлэхүүнд харьцуулан уг бүтцийн тоон нягт эсвэл агууламжийг гаргаж болно. Үүнийг бүтэц бүрийн хувьд тодорхойлж хооронд нь харьцуулан тус бүрийн эзлэх хувь хэмжээг тогтоож болно. Энэ тооцоог дээжийн өөр хэсэгт давтан гүйцэтгэж дээжийн дотор тухайн бүтцийн эзлэх хувийг дундажаар тодорхойлно. Энэ аргаар бид дээжийн доторхи тухайн бүтцийн агууламжийг тогтоохдоо нэг төрлийн олон янзын дээжийн өөр хэсэгт авагдсан хэд хэдэн зургийг ашиглав. Энэ аргаар тодорхойлоход дээжийн дотор аварга бүтцийн эзлэх хувь 60%, шугамлаг бүтцийн эзлэх хувь 34%, нанометрийн эрэмбийн хэмжээтэй жижиг хэсгийн эзлэх хувь 6% байна. Дээжийн дотор байгаа элемент бүрийн тоон нягтын харьцаа 1:6:11 байна. Бид энэ тооцоог хийхдээ өөрийн өргөнөөс ойролцоогоор 2 дахин болон түүнээс олон дахин их урттай хэсгүүдийг шугамлаг хэсэгт хамруулсан болно.

ТАЙЛБАР ДҮГНЭЛТ

Усан дотор явагдаж байгаа нуман ниргэлгийн үед үүсэж байгаа материалуудын SEM анализын дүнг үндэслэн эдгээрийн талаар бид дараах хэд хэдэн дүгнэлтийг гаргаж болно. Юуны өмнө

эдгээр хэсгүүд дан нүүрстөрөгчөөс тогтох бүтцүүд юм. Усан дотор явагдаж байгаа ниргэлгийн үед катод дээр урган бий болж байгаа биет хэсгийг бүрдүүлэгч жижиг хэсгүүд нь механикийн хувьд харилцан адилгүй шинж чанартай, дан нүүрстөрөгчөөс тогтох үндсэн гурван хэлбэртэй байна. Эдгээрийн дотроос нано хэмжээтэй шугаман хэсгүүд аль нэг хэсгээрээ заавал өөр нэг хэсэгтэй холбогдсон байдаг нь катодын гадаргуу дээр ургаж байгаа бүтцийн дотор ажиглагдах шугамлаг бүтцүүд (нано хоолой, нано утас) ихэвчлэн ургах замаар үүсдэг гэсэн дүгнэлтэд хүргэж байгаа юм. Нөгөө талаас богино хэмжээтэй ийм хэсгүүд үзүүр хэсэг рүүгээ үргэлж нарийссан байдаг нь үүнийг батлах нэг онцлог юм. Эндээс ургасан хэсгийн дотор байгаа нанометрийн эрэмбийн хэмжээтэй жижиг хэсгүүд болон аварга хэсгүүд нь нано эрэмбийн хэмжээний диаметртэй шугамлаг хэсгүүдийн ургах суурь нь болдог гэсэн дүгнэлтийг мөн гаргаж болно. Бидний гарган авсан дээжийн дотор шугамлаг хэсгийн эзлэх хувь 30% орчим байна. Мөн ургасан хэсгийн гадаргуу дээрх үелсэн бүтэцтэй бөмбөгүүд нь графитын эмх замбараагүй байрласан нүүрстөрөгчийн хоёр хэмжээст үеүдээс тогтох бөгөөд халалтын явцад эдгээр нь түүний гадаргуугаас салж дусал хэлбэрт шилжин ууршдагийг баталж байгаа юм.

Харин ниргэлгийн явцад электродаас салж буй хэсгүүд нь ихэвчлэн нимгэн үелсэн бүтэцтэй, эсвэл хоёр хэмжээст нүүрстөрөгчийн үеүдээс тогтох бараг микроны болон хэдэн арван микроны эрэмбэтэй том эсвэл бүр аварга том хэмжээтэй жижиг хэсгүүд болон шугаман хэмжээтэй янз бүрийн урттай хэсгүүдийг агуулсан байдаг. Микроны эрэмбийн хэмжээтэй болон аварга хэмжээтэй бөөмцөрүүдийн гадаргуу дээр хууларч буй хоёр хэмжээст үеүд тодорхой ажиглагддаг. Харин дангаараа хууларч салсан нимгэн үе огт тааралддаггүй. Эдгээр нь хуулрахдаа ихэвчлэн нэг үзүүр нь хуйлран эвхэгдэх байдлаар хуулардаг. Түүнчлэн эдгээр жижиг хэсгүүдийн гадаргуу дээр хууларч буй хоёр хэмжээст үеүд тодорхой ажиглагддаг. Энэ нь нүүрстөрөгчийн хоёр хэмжээс үеүд хуулрах явцдаа хуйлагдан нано хоолой, нано утас үүсгэдэг гэсэн дүгнэлт хийхэд өөрийн эрхгүй хүргэж байгаа юм. Ийм замаар үүссэн шугамлаг хэсгүүдийн онцлог нь харьцангуй урт, жигд өргөнтэй байгаа нь харагддаг. Тухайлбал, Зураг 2-т ажиглагдаж байгаа шугаман хэсгүүд

харгалзан 902.5 нм, 554.65 нм урттай байна. Иймд хоёр хэмжээст хавтгайг хуйлах замаар илүү урт шугамлаг бүтцүүдийг үүсгэх боломжтой юм.

ТАЛАРХАЛ

Энэ ажлыг гүйцэтгэхэд техникийн дэмжлэг үзүүлсэн ӨМӨЗО-ны БИС-ийн функциональ материалын лабораторийн эрхлэгч проф. О.Төгсөд гүн талархал илэрхийлье.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] Б.Бат-эрдэнэ, Усан дахь нуман ниргэлгийн катодын депозитын судалгаа, Магистрын ажил, 2010.
- [2] Schur D.V. et al., Proceedings of 9th International Conference on Heat Transfer, Fluid Mechanics and Thermodynamics, 16–18 July 2012, Malta, pp. 1711, 2012.
- [3] Y.Kim, J. Plasma Fusion Res. SERIES, Vol. 8, pp. 612, 2009.
- [4] И.В. Карпов и др, Журнал технической физики, том 84, вып. 4, стр. 93, 2014.
- [5] J. G. Darias González, Proceedings of the XV Workshop on Nuclear Physics and IX International Symposium on Nuclear and Related Techniques, February 9-13, 2015, Havana, Cuba, pp. 7, 2015.
- [6] M. K. Sanyal, Pure Appl. Chem., Vol. 74, No. 9, pp. 1553, 2002.
- [7] R.Sharma et al., Cogent Engineering, 2: 1094017, 2015.
- [8] T.K. Sham, Int. J. Nanotechnol., Vol. 5, pp. 1194, 2008.
- [9] M.V.Antisari, Carbon, v. 41, pp. 2393, 2003.

Цөмийн өгөгдлийн JENDL-3.3 болон JENDL-4.0 санг ашигласан үр дүнгийн харьцуулалт

Т.Жамъянсүрэн^а, С. Одмаа^{а,б,*}

^а Хими, биологийн инженерчлэлийн тэнхим, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Монгол улсын их сургууль

^б Цөмийн физикийн судалгааны төв, Монгол улсын их сургууль

Судалгааны ажлаар Дорнод аймагт байрлах Улааны полиметаллын ордын цөөн дээжид нейтрон идэвхжлийн болон рентгенфлуоресценцийн шинжилгээгээр үндсэн элементээс гадна ховор шорооны, мөн үнэт металл тодорхойлох зорилго тавин ажиллав. Нейтрон идэвхжлийн шинжилгээний туршилт хэмжилтийг ОХУ-д байрлах ЦШНИ-ийн Цөмийн урвалын лабораторийн электроны хурдасгуур МТ-25 микротрон, гамма спектрометрийн системийг ашиглан хийсэн ба рентгенфлуоресценцийн шинжилгээг МУИС-ийн ЦФСТ – ийн рентген спектрометр дээр хийж гүйцэтгэв. Хэмжилтээр полиметаллын хүдрийн дээжид үндсэн элементээс гадна Sc, Y, La, Ce, Eu, Nd зэрэг ховор шорооны элемент, алт 0.05 – 1 ppm, уран 200 – 500 ppm, тори 10 – 90 ppm агуулгатай гарсан нь сонирхол татахуйц үр дүн юм. Судалгааг цааш үргэлжлүүлэн шинжилгээний бусад аргаар элементийн агуулгыг нарийвчлан тогтоох, бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх боломжтой харагдав. Энэхүү судалгааны ажлыг “Цөмийн цацрагийн хэрэглээ” сэдэвт ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.

I. ОРШИЛ

Бид өмнөх судалгааны ажлууддаа реакторыг амжилттай унтраасны дараа голомтонд хуримтлагдсан хуваагдлын бүтээгдэхүүнүүдийн задралаас үүсэх дулааныг идэвхгүйгээр зайлуулах чадвартай, голомтын төвдөө нэг блокон ойлгогчтой, 100 МВт дулааны чадалтай, 850°C температурт ажиллах, призм төрлийн өндөр температурын хийн хөргөлттэй реакторын (ӨТХР) дизайныг хийж, критик байдлын болон түлшний шаталтын тооцооллыг гүйцэтгэсэн [1-3]. Эдгээр нейтроник тооцооллыг Японы Атомын энергийн Агентлагаас хөгжүүлсэн нейтроны тасралтгүй энергийн мужид болох шилжилтийг Монте Карло аргаар тооцоолдог MVP2.0 [4] болон MVP-BURN [5] компьютерийн кодуудыг, цөмийн урвалын өгөгдлийн сан JENDL-3.3 [6]-ийн хамт ашиглан хийсэн. Бид тооцооллын үр дүнгээ Одмаа, Обара нар [7]-ын гүйцэтгэсэн ажлынхтай харьцуулсан ба уг ажилд JENDL4.0 [8] өгөгдлийн санг ашигласан байдаг. Манай төв энэ сангийн шинэ хувилбарыг хараахан авч амжаагүй байсан тул хуучин (JENDL3.3) санг ашиглан тооцооллоо гүйцэтгэсэн.

Энэ удаа өмнөх [1-3] ажилд авч үзсэн 100 МВт-ийн ӨТХР-ийн голомтын дизайны нейтроник тооцооллыг JENDL-4.0 санг ашиглан гүйцэтгэж, үр дүнг харьцуулав.

II. ТООЦООЛЛЫН АРГА ЗҮЙ

Төвдөө ойлгогчтой, призм төрлийн, ӨТХР-ийн голомтыг түлшний эвлүүлгийн, удирдлагын савааны, ойлгогчийн гэсэн гурван өөр дизайнтай, зургаан өнцөгт призмэн блокууд бүрдүүлэх ба эдгээрийг давхарлан өрж цилиндр хэлбэр үүсгэнэ. Өмнөх ажлуудад [1-3] призм төрлийн 100 МВт-ийн дулааны чадалтай, 2.49 м голомтын эффектив радиустай, 6.38 м өндөртэй, төвийн ойлгогчийн радиус 0.18 м, голомтын дундаж чадлын нягт 0.82 Вт/см³ байх, 20% баяжуулсан UO₂ бүхий TRISO түлш ашигласан ӨТХР-ийн голомтын нейтроник тооцооллыг JENDL-3.3 өгөгдлийн санг ашиглан гүйцэтгэсэн. Энэхүү ажилд дээрх реакторын голомтын параметр болон ажиллах нөхцлийг өөрчлөхгүйгээр JENDL-4.0 санг ашиглан нейтроник тооцооллыг дахин гүйцэтгэсэн. Тооцоололд бүх удирдлагын савааг голомтоос гарган, үүсэх орон зайг гелийн хийгээр дүүргэсэн тохиолдолд гүйцэтгэсэн. MVP2.0 кодоор реакторын голомт дэх нейтрон үржүүлэгч эффектив фактор ($k_{\text{эфф}}$)-ыг тооцоолохдоо голомт дотор үүссэн нейтонуудын санамсаргүй алхалтуудыг тооцоолохын тулд тэдний мөрийн уртыг үнэлэх, мөргөлдөөний нягтыг үнэлэх, болон аналог үнэлэгч гэсэн үндсэн гурван факторыг тооцон үзэж хамгийн их магадлалтай утгаар тооцдог [4]. Монте Карло арга нь голомтод үүссэн

* Electronic address: odmaa@seas.num.edu.mn

нейтроноор үүсэх харилцан үйлчлэлийн процессуудын санамсаргүй үзэгдлийг үнэлдэг тул тооцооллыг хамгийн оновчтой болгох нөхцлийг бодлого тус бүрт тогтоох шаардлагатай байдаг. Манай голомтын тооцооллын хувьд реакторт үүссэн нэг нейтрон 50000 ялгаатай харилцан үйлчлэл (түүхийн тоо=50000) хийнэ, нийтдээ хуваагдлын 100 нейтрон (хуваагдлын нейтроны тоо=100)-ийн санамсаргүй харилцан үйлчлэлийг авч үзэхээр тооцооллыг гүйцэтгэсэн. Статистик боловсруулалтын үр дүнг сайжруулахын тулд эхний 20 нейтроны харилцан үйлчлэлийг тооцоогүй болно. Манай голомтын тооцооллын хувьд реакторт үүссэн нэг нейтрон 100000 ялгаатай харилцан үйлчлэл (түүхийн тоо=100000) хийнэ, нийтдээ хуваагдлын 100 нейтрон (хуваагдлын нейтроны тоо=100)-ийн санамсаргүй харилцан үйлчлэлийг авч үзэхээр тооцооллыг гүйцэтгэсэн. Статистик боловсруулалтын үр дүнг сайжруулахын тулд эхний 20 нейтроны харилцан үйлчлэлийг тооцоогүй болно.

III. ТООЦООЛЛЫН ҮР ДҮН


Тооцооллын үр дүнг Хүснэгт 1 болон Зураг 1-д харьцуулан харуулав. Үр дүнгээс харахад JENDL-4.0 урвалын сангийн өгөгдлийг ашиглахад реактор ажиллаж эхлэх үеийн $k_{\text{эф}}$ утга нь 0.03% илүү, реактивити 0.01-ээр буурсан байна, харин голомтын нэг циклийн үргэлжлэх хугацаа болон түлшний шаталт багассан байна.

Хүснэгт 1. ӨТХР-ийн голомтын нейтроник анализын үр дүн цөмийн өгөгдлийн сангаас хамаарах нь.

Цөмийн өгөгдлийн сан	$k_{\text{эф},0}$ (алдаа %)	ХИУ $\Delta k/k$ (%)	$t_{\text{голомт}}$ (жил)	$V_{\text{түлш},t}$ (ГВт*хоног/тн)
JENDL-3.3	1.4972 (0.01)	33.21	33.6	135.0
JENDL-4.0	1.4974 (0.01)	33.22	26.4	106.0

Тайлбар:


$k_{\text{эф},0}$ алдаа	Реактор ажиллаж эхлэх үеийн $k_{\text{эф}}$ статистик хазайлт
ХИУ $\Delta k/k$	Реактивитийн хамгийн их утга
$t_{\text{голомт}}$	Голомт дэх түлшний нэг циклийн үргэлжлэх хугацаа
$V_{\text{түлш},t}$	Нэг циклийн төгсгөлд түлшний шаталт



Зураг 1. Цөмийн өгөгдлийн сангаас хамаарч нейтрон үржүүлэх эффектив фактор нь голомтын ажиллах хугацаанаас өөрчлөгдөх нь.

Цөмийн урвалын өгөгдлийн сангаас хамааран нейтроник үзүүлэлтүүд өөрчлөгдөж байгааг тайлбарлая.

JENDL 4.0 санд түлш шатсанаар голомтод үүсэх голлох болон минор актиноидууд, хуваагдлын бүтээгдэхүүнүүдийн хөндлөн огтлолыг шинээр үнэлсэн, мөн 30 хуваагдлын болон 39 хүнд масстай изотопын урвалын огтлол шинээр нэмэгдэж орж ирсэн [8, 9]. Зураг 2-т голомт даяарх нейтроны урсгалыг JENDL-3.3, -4.0 өгөгдлийн санг ашиглан тооцоолсон үр дүнг харуулав.




Зураг 2. Голомт даяарх нейтроны урсгал цөмийн урвалын өгөгдлийн сангаас хамаарах нь.

Зураг 2-оос харахад дээр өгүүлсэнчлэн JENDL 4.0 санд нейтрон шингээгч олон изотопыг шинээр тооцсон учраас нейтроны урсгал нейтроны энергийн бүх мужид багассан байна. Одоо хоёр өгөгдлийн санд авч үзсэн зарим изотопуудад явагдах голомт даяарх цөмийн урвалын хурдыг авч үзье.

Реактор ажиллаж эхлэх үед голомт дэх бүх цөмд нейтрон шингээгдэх (шингээгдэх = хуваагдал (n,f) + залгих (n,γ)) болон сарних урвалын хурдны харьцааг нейтроны энергийн дөрвөн мужид Зураг 3-д харуулав. Зургаас харахад реактор ажиллаж эхлэх үед цөмийн өгөгдлийн сан JENDL-4.0 дэх изотопуудад дулааны нейтрон шингээгдэх болон сарних урвалын хурдны харьцаа JENDL-3.3-ээс харьцангуй их, бусад нейтроны тохиолдол эсрэгээрээ байна.

ӨТХР нь дулааны реактор учраас Хүснэгт 1-д харуулснаар нейтрон үржүүлэх эффе́ктив фактор нь JENDL-4.0 санг ашиглан тооцоолоход 0.03% илүү гарч байна.



Зураг 3. Реактор ажиллаж эхлэх үеийн цөмийн өгөгдлийн урвалын сангуудаас хамаарсан голомт даяар нейтрон шингээгдэх болон сарних урвалын хурдуудын харьцаа.

Реактор ажиллаж эхлэх үед голомт дахь ураны гол изотопуудын хуваагдах болон залгих (n,γ) урвалын хурдны харьцааг JENDL-3.3 ба -4.0 санг ашиглан нейтроны энергийн мужаас хамааруулан тооцсон үр дүнг Хүснэгт 2-т харуулав. Хүснэгтээс харахад JENDL 4.0 санд U^{235} -ийн хуваагдах урвалын хурдууд бүх энергийн мужид, харин залгих урвалын хурд нь бага энергийн мужид JENDL 3.3-ийнхтэй адил, U^{238} -ийн хувьд бүх энергийн мужид (1-20 МэВ-ээс бусад) хуваагдах урвалын хурд ихэсч, залгих урвалын хурд адил байна.


Цөмийн урвалын өгөгдлийн дээрх хоёр санд U^{235} хуваагдагч цөмийн хуваагдах болон залгих урвалын огтлол адилхан, харин JENDL 4.0 санд авч үзсэнээр U^{238} хуваагдахуйц цөмийн залгих урвалын огтлол багасч, хуваагдах урвалын огтлол ихэссэн байсан [8]. Иймд Зураг 4-д харуулснаар JENDL 4.0 санд бага энергийн мужид шингээгдэх буюу хуваагдах урвал илүү явагдсан тул Хүснэгт 1-д үзүүлсэн реактор ажиллаж эхлэх үеийн нейтрон үржүүлэгч эффе́ктив факторын утга бага зэргийн өндөр гарсан байна.

Хүснэгт 2. Реактор ажиллаж эхлэх үед U^{235} , U^{238} -ийн хуваагдах урвалын хурд (R_f) болон залгих (n,γ) урвалын хурдыг (R_c) JENDL-3.3 ба -4.0 санг ашиглан нейтроны энергийн мужаас хамааруулсан үр дүн.

Нейтроны энергийн муж	Реактор ажиллаж эхлэх үед			
	$R_f(JENDL3.3)/R_f(JENDL4.0)$		$R_c(JENDL3.3)/R_c(JENDL4.0)$	
	U^{235}	U^{238}	U^{235}	U^{238}
$10^{-5} - 1$ эВ	1.00	0.70	1.00	1.01
1 эВ - 1 кэВ	1.00	0.76	1.01	1.00

1 кэВ - 100 кэВ	1.00	0.55	1.14	1.00
100 кэВ - 1 МэВ	1.00	0.98	0.98	0.99
1 МэВ - 20 МэВ	1.01	1.00	1.05	0.99

Реактор ажиллаж дуусах үед голомт дэх бүх цөмд нейтрон шингээгдэх болон сарних урвалын хурдны харьцааг нейтроны энергийн дөрвөн мужид Зураг 5-д харуулав.



Зураг 5. Реактор ажиллаж дуусах үеийн цөмийн өгөгдлийн урвалын сангуудаас хамаарсан голомт даяар нейтрон шингээгдэх болон сарних урвалын хурдуудын харьцаа.

Зургаас харахад JENDL3.3 сантай харьцуулахад JENDL4.0 сан дэх изотопуудад энергийн бүх мужийн нейтроноуд арай их шингээгдэж байна. Реактор ажиллаж дуусах үед голомт дахь ураны изотопуудын хуваагдах болон залгих (n,γ) урвалын хурдны харьцааг JENDL-3.3 ба -4.0 санг ашиглан нейтроны энергийн мужаас хамааруулан тооцсон үр дүнг Хүснэгт 3-д харуулав.

Хүснэгт 3. Реактор ажиллаж дуусах үед U^{235} , U^{238} -ийн хуваагдах урвалын хурд (R_f) болон залгих (n,γ) урвалын хурдыг (R_c) JENDL-3.3 ба -4.0 санг ашиглан нейтроны энергийн мужаас хамааруулсан үр дүн.

Нейтроны энергийн муж	Реактор ажиллаж дуусах үед			
	$R_f(JENDL3.3)/R_f(JENDL4.0)$		$R_c(JENDL3.3)/R_c(JENDL4.0)$	
	U^{235}	U^{238}	U^{235}	U^{238}
$10^{-5} - 1$ эВ	0.93	0.94	0.93	1.36
1 эВ - 1 кэВ	0.71	0.76	0.72	1.03
1 кэВ - 100 кэВ	0.70	0.54	0.79	0.99
100 кэВ - 1 МэВ	0.70	0.96	0.72	0.97
1 МэВ - 20 МэВ	0.70	0.99	0.73	0.98

Хүснэгт 3-ийг харвал JENDL4.0 санг ашиглахад нейтроны энергийн бүх мужид U^{235} изотопын хуваагдах болон залгих урвалын хурд ихэсч, U^{238} изотопын хувьд нейтроны энергийн бүх мужид хуваагдах энергийн хурд ихэсч, харин бага энергийн мужид залгих урвалын хурд буурсан байна. Энэ нь реактор ажиллаж эхлэх үеийнхээс (Хүснэгт 2) өөр байгаа нь түлш шатсанаар голомтод нейтроноор хуваагдах болон залгих

огтлол өндөртэй голлох болон минор актиноидууд, хуваагдлын бүтээгдэхүүнүүд байдаг. JENDL 4.0-д JENLD 3.3-ийг бодвол 69-оор олон изотопууд нейтрон шингээж байгаа тул ураны хоёр изотопд шингээгдэж урвал явуулах нейтроны хэмжээ цөөрснөөр харгалзах урвалын хурд багассан байна.

Реактор ажиллаж дуусах үед голомт дахь минор актиноидын изотопуудын хуваагдах болон залгих (n, γ) урвалын хурдны харьцааг, харин зарим хуваагдлын бүтээгдэхүүний залгих урвалын хурдны харьцааг JENDL-3.3 ба -4.0 санг ашиглан нейтроны энергийн мужаас хамааруулан тооцсон үр дүнг Хүснэгт 4, 5-д харуулав.

Хүснэгт 4. Реактор ажиллаж дуусах үед минор актиноидуудын хуваагдах урвалын хурд (R_f) болон залгих (n, γ) урвалын хурдыг (R_c) JENDL-3.3 ба -4.0 санг ашиглан нейтроны энергийн мужаас хамааруулсан үр дүн.

Нейтроны энергийн муж	$R_f(JENDL3.3)/R_f(JENDL4.0)$				$R_c(JENDL3.3)/R_c(JENDL4.0)$			
	Pu ²³⁹	Np ²³⁷	Am ²⁴¹	Cm ²⁴²	Pu ²³⁹	Np ²³⁷	Am ²⁴¹	Cm ²⁴²
10 ⁻⁵ – 1 эВ	1.14	1.85	1.64	2.05	1.14	1.78	1.36	1.52
1 эВ – 1 кэВ	0.88	1.45	1.17	1.16	0.89	1.38	1.08	1.13
1 кэВ – 100 кэВ	0.86	1.71	1.09	1.36	0.89	1.52	1.24	0.82
100 кэВ -1 МэВ	0.84	1.41	1.11	1.42	0.89	1.37	1.13	0.74
1 МэВ – 20 МэВ	0.85	1.44	1.13	1.39	0.84	1.32	1.50	0.91

Реактор ажиллаж дуусах үед үүссэн минор актиноидуудын атомын нягтын харьцааг Хүснэгт 5-д харуулав.

Хүснэгт 5. Реактор ажиллаж дуусах үед минор актиноидуудын атомын нягт (атом/барн-см) JENDL-3.3 ба -4.0 сангаас хамаарах нь.

Минор актиноид	JENDL-3.3	JENDL-4.0	JENDL-3.3/JENDL-4.0
Np237	4.04E-03	2.88E-03	1.41
Pu239	1.09E-02	1.31E-02	0.83
Am214	1.08E-03	9.86E-04	1.09
Cm-242	1.03E-04	1.03E-04	1.00

Хүснэгт 4-д минор актиноидуудын (Pu²³⁹-оос бусад) хуваагдах урвалын хурд нь нейтроны энергийн бүх мужид JENDL 4.0 санг ашигласан тохиолдолд буурсны шалтгаан бол уг санд эдгээрийн хуваагдах урвалын огтлол багассан [8], мөн Зураг 1-д үзүүлснээр нейтроны урсгал буурсан, Хүснэгт 5-д харуулснаар атомын нягт цөөрсөнтэй холбоотой. Харин JENDL 4.0 санд минор актиноидын залгих урвалын огтлол их ч, Зураг 1-д харуулсан нейтроны урсгал болон Хүснэгт 5 дэх атомын нягт буурсан учраас

Хүснэгт 4-д харуулснаар залгих урвалын хурд нь багассан байна.

Реактор ажиллаж дуусах үед голомт дахь зарим хуваагдлын бүтээгдэхүүнүүдийн залгих (n, γ) урвалын хурдны харьцааг JENDL-3.3 ба -4.0 санг ашиглан нейтроны энергийн мужаас хамааруулан тооцсон үр дүнг Хүснэгт 6-д, атомын нягтын харьцааг Хүснэгт 7-д харуулав.

Хүснэгт 6. Реактор ажиллаж дуусах үед зарим хуваагдлын бүтээгдэхүүнүүдийн залгих (n, γ) урвалын хурдыг (R_c) JENDL-3.3 ба -4.0 санг ашиглан нейтроны энергийн мужаас хамааруулсан үр дүн.

Нейтроны энергийн муж	$R_c(JENDL3.3)/R_c(JENDL4.0)$					
	Zr ⁹⁵	I ¹³⁵	Xe ¹³⁵	Sm ¹⁴⁹	Eu ¹⁵⁵	Gd ¹⁵⁷
10 ⁻⁵ – 1 эВ	1.33	1.32	1.29	1.05	1.80	1.40
1 эВ – 1 кэВ	0.99	1.03	0.97	0.76	1.54	0.87
1 кэВ – 100 кэВ	0.99	1.00	1.87	0.82	1.52	0.92
100 кэВ -1 МэВ	1.15	0.99	2.26	0.78	1.66	0.91
1 МэВ – 20 МэВ	0.93	1.00	3.09	0.67	2.90	1.01

Хүснэгт 7. Реактор ажиллаж дуусах үед зарим хуваагдлын бүтээгдэхүүнүүдийн атомын нягт (атом/барн-см) JENDL-3.3 ба -4.0 сангаас хамаарах нь.

Хуваагдлын бүтээгдэхүүн	JENDL-3.3	JENDL-4.0	JENDL-3.3/JENDL-4.0
Zr-95	1.08E-04	1.13E-04	0.96
I-135	5.13E-07	5.21E-07	0.99
Xe-135	5.98E-07	6.44E-07	0.93
Sm-149	1.58E-05	2.17E-05	0.73
Eu-155	4.50E-05	3.13E-05	1.44
Gd-157	8.67E-07	9.49E-07	0.91

Хүснэгт 6-д үзүүлсэн зарим хуваагдлын бүтээгдэхүүний залгих урвалын хурд нь JENDL 4.0 сан ашигласан тохиолдолд буурсны шалтгаан бол хэдийгээр уг санд эдгээрийн залгих урвалын огтлол бараг өөрчлөгдөөгүй [8] ба Хүснэгт 5-д харуулснаар атомын нягт ихэссэн ч, Зураг 1-д үзүүлснээр голомт даяарх нейтроны урсгал хоёр эрэмбээр буурсантай холбоотой юм. Иймд JENDL4.0 санд нейтрон шингээгч изотоп олныг нэмж оруулснаар голомт даяар нейтроны урсгал багассан (Зураг 1) тул U²³⁵-ийн хуваагдах хурд буурснаар (Хүснэгт 3) JENDL 3.3 санг ашигласантай харьцуулбал шаталт 29 ГВт*хоног/тн-оор, голомтын ажиллах хугацаа ойролцоогоор 7 жилээр богиносоход хүргэж байна.

ДҮГНЭЛТ

1. Энэ ажилд 100 МВт чадлын, төвдөө нэг ойлгогчин блоктой, цагираган хийцтэй, призмэн ОТХР-ийн голомтын нейтроник тооцоолол болон түлшний шаталтын цөмийн урвалын өгөгдлийн JENDL -3.3, -4.0 санг ашиглан гүйцэтгэв.
2. JENDL 4.0 санд нейтроныг шингээгч 69 изотопыг шинээр тооцож авч үзсэнээр голомт даяарх нейтроны урсгал буурсныг харуулав.
3. JENDL 4.0 санг ашиглахад нейтроны бага энергийн мужид шингээгдэх (хуваагдах+залгих) урвалын хурд ихэссэн тул реактор ажиллаж эхлэх үед нейтрон үржүүлэх эффектив фактор 0.03%-иар ихэссэн болохыг тогтоов.
4. Харин реактор ажиллаж дуусах үед JENDL 4.0 санг ашиглахад нейтроны энергийн бүх мужид шингээгдэх урвалын хурд ихэссэн ч, U^{235} -ийн хуваагдах урвалын хурд буурсан тул голомтын ажиллах хугацаа болон түлшний шаталт 29 ГВт*хоног/тн-оор буурсаныг олов.

НОМЗҮЙ

- [1] Т.Жамъянсүрэн, С.Одмаа, Н.Норов, Б.Мөнхбат. Бага чадлын өндөр температурын хийн реакторын голомтын дизайны судалгаа. Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал. Байгалийн ухааны салбар. 2016.10.29. Хүрэлтогоот-2016 эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Улаанбаатар. хх24-28.
- [2] S.Odmaa, T.Jamyansuren, O.Toru, N.Norov and B.Munkhbat. Design parameters in an annular, prismatic HTGR for passive decay heat removal. *Annals of Nuclear Energy*, 111 (2018) 441-448.
- [3] С. Одмаа, Т. Жамъянсүрэн, Н. Норов. Задралын дулаанаа идэвхгүйгээр зайлуулах чадвартай, төвдөө ойлгогчтой, өндөр температурын хийн хөргөлттэй реакторын голомтын дизайны судалгаа. МУИС, Физик.25(478) 2017, 34-40
- [4] Nagaya Y et al. MVP/GMVP II: general-purpose Monte Carlo code for neutron and photon transport calculations based on continuous energy and multigroup methods. JAERI-1348. Japan: Japan Atomic Energy Research Institute; 2005.
- [5] Okumura K et al. MVP-BURN user's manual. Japan: Atomic Energy Agency; 2005.
- [6] K. Shibata, T. Kawano, T. Nakagawa, O. Iwamoto, J. Katakura, T. Fukahori, S. Chiba, A. Hasegawa, T. Murata, H. Matsunobu, T.

Ohsawa, Y. Nakajima, T. Yoshida, A. Zukeran, M. Kawai, M. Baba, M. Ishikawa, T. Asami, T. Watanabe, Y. Watanabe, M. Igashiri, N. Yamamuro, H. Kitazawa, N. Yamano and H. Takano: "Japanese Evaluated Nuclear Data Library Version 3 Revision-3: JENDL-3.3," J. Nucl. Sci. Technol. 39, 1125(2002)

- [7] S.Odmaa and T.Obara. Neutronic and thermo-hydraulic analyses of a small, long-life HTGR for passive decay-heat removal. *Journal of Nuclear Science and Technology*, 52, Issue 12, 2015, pp1519-1529. <http://dx.doi.org/10.1080/00223131.2015.1017546>
- [8] K. Shibata, O6 Iwamoto, T. Nakagawa, N. Iwamoto, A. Ichihara, S. Kunieda, S. Chiba, K. Furutaka, N. Otuka, T. Ohsawa, T. Murata, H. Matsunobu, A. Zukeran, S. Kamada, and J. Katakura: "JENDL-4.0: A New Library for Nuclear Science and Engineering," J. Nucl. Sci. Technol.. 48(1), 1-30(2011).
- [9] Go. Chiba, Keisuke Okumura, Kazuteru Sugino, Yasunobu Nagaya, Kenji Yokoyama, Teruhiko Kugo, Makoto Ishikawa and Shigeaki Okajima. JENDL-4.0 Benchmarking for Fission Reactor Applications. *Journal of Nuclear Science and Technology*, Vol. 48, No 2. p.172-182.

SU(2) ба SU(3) бүлэгт суурилсан латтис гэйж онолуудаас гарах физик үр дүнгүүдийн ялгаа

Г. Энхтуяа*, Ч. Содбилэг, П. Баттогтох

Латтис КХД-ын лаборатори, Онолын физикийн салбар, Физик технологийн хүрээлэн, Шинжлэх ухааны академи

Энэ ажлаар бид кварк хоорондын өнгөний харилцан үйлчлэлийг илэрхийлдэг SU(2) ба SU(3) бүлэгт суурилсан онолууд, тэдгээрийн ялгаатай болон адил талуудыг судлав. Мөн эдгээр онолуудаас гарах физик үр дүнгүүдийн ялгааг өмнө нь хийгдсэн ажлуудыг харьцуулах замаар тодорхойллоо. Ингэхдээ урсгалын хоолойн өргөн, таталцлын коэффициент, кварк хоорондын потенциал зэрэг хэмжигдэхүүнүүдийг харьцуулсан. Харьцуулсан бүх хэмжигдэхүүнүүдийн хувьд SU(3) онолоос гарсан үр дүн нь SU(2) онолоос гарсан үр дүнгээс тоон утгаараа их байгааг олж тогтоолоо.

PACS numbers: 11.15 Na, 12.38 Gc.

I. ОРШИЛ

Цэвэр SU(N) онол нь их температур дахь деконфайнмент фазаас бага температуртай конфайнмент фаз руу шилжих фазын шилжилтийг илэрхийлдэг. SU(2) болон SU(3) групууд нь абелын бус гэйж групууд юм. SU(2) гэйж груп нь гурван үүсгэгчтэй Паулын матрицаар илэрхийлэгддэг. SU(3) гэйж груп нь найман үүсгэгчтэй Гейл Манн матрицаар илэрхийлэгддэг. Квант хромодинамикт дээрх хоёр груп нь кваркуудын хоорондын “өнгө”-ний харилцан үйлчлэлийг илэрхийлдэг. SU(2) группыг кваркуудын хоорондох харилцан үйлчлэлийг тооцохдоо илүү хялбар, ерөнхий тохиолдол болгон ашигладаг. Гэсэн хэдий ч энэ бүлэгт суурилсан онол нь кварк хоорондын харилцан үйлчлэлийн талаар тодорхой, чухал мэдээллүүдийг өгч чаддаг. Харин кваркуудын өнгөний харилцан үйлчлэлийг бүрэн, яг нарийн илэрхийлэх онол бол SU(3) бүлэгт суурилсан онол юм. Кваркуудын хоорондын харилцан үйлчлэлийг зөөдөг найман төрлийн глюон байдаг бөгөөд SU(3) группын найман үүсгэгч нь эдгээр глюонуудыг илэрхийлнэ. Дээрх хоёр группэд суурилсан онолоос гарах физик үр дүнгүүд нь шинж чанар, хамаарлын хувьд адил боловч тоон утгын хувьд ялгаа гардаг. Мөн эдгээр хоёр онол нь кваркуудын конфайнмент төлвөөс деконфайнмент төлөвт шилжих фазын шилжилтийн эрэмбээрээ ялгаатай. Өөрөөр хэлбэл, SU(2) бүлэгт суурилсан онол нь хоёрдугаар эрэмбийн фазын шилжилттэй бол SU(3) нь нэгдүгээр эрэмбийн фазын шилжилттэй. Хоёрдугаар эрэмбийн фазын шилжилт нь тасралтгүй шинж чанартай байдаг

бол нэгдүгээр эрэмбийн фазын шилжилт нь тасралттай шинж чанартай байдаг. Тиймээс деконфайнмент төлөвт шилжиж байгааг илэрхийлж, эрэмбийн параметр болдог физик хэмжигдэхүүнүүдийн шинж чанар нь деконфайнмент болох цэг дээр ялгаатай байдаг. Finite-size scaling шинж чанарыг судласнаар фазын шилжилтийн эрэмбийг ялгаж, бэхэлж өгдөг. Өөрөөр хэлбэл, хоёрдугаар эрэмбийн фазын шилжилтийн хувьд finite-size эффект үр дүнд тийм ч их нөлөө үзүүлдэггүй байхад нэгдүгээр эрэмбийн шилжилтийн хувьд finite-size эффект чухал нөлөөтэй байдаг. Тухайлбал, өгөгдсөн N_t -ийн хувьд критик температурт харгалзах критик холбоосын тогтмол (β_c)-ийг тогтооход SU(2) онолын тохиолдолд тухайн нэг огторгуйн эзлэхүүнтэй латтис дээр тодорхойлсон β_c бусад өөр, ялгаатай эзлэхүүний хувьд ижил тодорхойлогддог бол SU(3) онолын хувьд критик холбоосын тогтмол латтисын огторгуйн эзлэхүүнээс хамаарч өөрчлөгдөж байдаг буюу өөрөөр хэлбэл, латтисын эзлэхүүн ихсэхэд β_c -ийн утга ихэсдэг. Тиймээс бид SU(3) онолын хувьд тухайн нэг N_t -д харгалзах β_c -ийн тодорхой нэг утгыг ашиглахын тулд хязгааргүй эзлэхүүнтэй байх термодинамик хязгаар руу экстраполяци хийх шаардлагатай болдог. Экстраполяци хийх энэ үйлдэл нь дараах


$$\beta_c(N_t, \infty) = \beta_c(N_t, N_s) - h \left(\frac{N_t}{N_s} \right)^3 \quad (1)$$

гэсэн тэгшитгэлийн дагуу хэрэгждэг [1]. Энд $h \leq 0.1$ байна. Тиймээс латтисын орон зайн том эзлэхүүн болон өндөр статистик нь нэгдүгээр эрэмбийн шилжилтийн цэвэр сигналыг ялгаж авахад шаардлагатай байдаг. Мөн нэгдүгээр

* Electronic address: enkhutuya.galsandorj@gmail.com

эрэмбийн шилжилтийн цэвэр сигналыг гарган авахад латтисын огторгуйн өргөсөлт N_s нь хугацааны өргөсөлт N_t -аас хамгийн багадаа зургаа дахин их байх ёстой гэдгийг [2]-д тогтоосон байдаг. $SU(2)$ гэйж онолын тохиолдолд бид үр дүнг гурван хэмжээст Ising моделин үр дүнтэй харьцуулж, шалгаж үздэг бол $SU(3)$ гэйж онолын тохиолдолд бид оронд нь гурван-төлөвт Potts моделиг авч үздэг. Мөн $SU(2)$ нь $Z(2)$ төвийн симметртэй байдаг бол $SU(3)$ нь $Z(3)$ төвийн симметртэй байдаг.

КХД-ын фазын диаграмыг авч үзвэл нэгдүгээр эрэмбийн фазын шилжилт нь барионы нягт өндөр байх мужид тохиолдоно гэж үздэг. Зураг 1-т фазын диаграммын зургийг харууллаа. Зургаас нэг ба хоёрдугаар эрэмбийн фазын шилжилтүүд болох критик цэгүүдийг харж болно.



Зураг 1. КХД-ын фазын диаграм.

Quenched ойролцоолол буюу динамик кваркуудыг тооцоогүй цэвэр гэйж орны тохиолдолд деконфайнмент болох критик температур нь $SU(3)$ онолд 208МэВ, 260МэВ, 280МэВ зэрэг утгууд тодорхойлогддог бөгөөд энэ нь $SU(2)$ онолоос гардаг үр дүнтэй харьцуулахад их утгатай байна. Кваркуудын төрлүүдийг тооцох үед энэ утга буурдаг. Энэхүү өгүүлэл нь дөрвөн бүлгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт оршил хэсгийг, хоёрдугаар бүлэгт нэг ба хоёрдугаар эрэмбийн шилжилтүүдийн талаар, тэдгээрийн онцлогуудын талаар онолын хэсгийг тус тус багтаасан. Гуравдугаар бүлэгт физик хэмжигдэхүүний тоон утганд гардаг ялгааг эдгээр онолуудаас гарсан үр дүнгүүдийг харьцуулан тодорхойлсон. Бүлэг дөрөвт дүгнэлтийг оруулсан.

II. ЭРЭМБИЙН ПАРАМЕТРУУД

A. Таталцлын коэффициент

Конфайнмент үзэгдлийн гол учир шалтгаан болсон зайнаас шугаман хамаарч өсдөг потенциал нь температур ихсэхэд буурч эхэлдэг. Ийнхүү буурсаар деконфайнмент болох критик температур дээр тэг болж байвал хоёрдугаар эрэмбийн фазын шилжилт, температураас хамаарч буурсан хэдий ч критик температур дээр тодорхой утгатай байвал нэгдүгээр эрэмбийн фазын шилжилт явагдаж байна гэж үздэг. Энэхүү температураас хамаарч потенциал буурч байгаагийн шалтгаан нь потенциалын зайнаас шугаман хамаарлын коэффициент болох таталцлын коэффициент (σ) нь температураас хамаарч буурч эхэлдэгээс болдог. Тиймээс энэ таталцлын коэффициентын бууралт нь мөн дээрх потенциалтай нэгэн адил хамаарлаар нэг, хоёрдугаар эрэмбийн фазын шилжилтийг ялгадаг. Өөрөөр хэлбэл, нэгдүгээр эрэмбийн шилжилтийн үед критик температур дээр тэг бус утгатай байдаг бол хоёрдугаар эрэмбийн шилжилтийн үед таталцлын коэффициент температураас хамаарч тасралтгүй буурсаар критик температур дээр тэг болдог. Тиймээс таталцлын коэффициент σ нь $SU(2)$ онолын тохиолдолд конфайнмент болон деконфайнмент фазуудыг ялгах эрэмбийн параметр болон ашиглагддаг. $SU(3)$ онолоор таталцлын коэффициентыг тооцохдоо $SU(2)$ онолд бидний тооцоолдог байсан аргатай ижил техник хэрэглэн гаргаж авдаг.

Температураас хамааралтай таталцлын коэффициентыг түүний тэг температур дээрх утганд нормчлоход Nambu-Goto-ын моделээр илэрхийлэгддэг. $SU(2)$ онолд

$$\frac{\sigma(T)}{\sigma(0)} = \sqrt{1 - \frac{T^2}{T_c^2}} \quad (2)$$

гэж өгөгддөг бол $SU(3)$ онолд


$$\frac{\sigma(T)}{\sigma(0)} = a \sqrt{1 - b \frac{T^2}{T_c^2}} \quad (3)$$

гэж өгөгддөг [3]. Тэгшитгэл 3-д байгаа a , b коэффициентуудын утгууд нь энэ тэгшитгэлийн дагуу таталцлын коэффициентын датанд фит хийснээр гарч ирдэг. Энэ нь критик температур дээрх таталцлын коэффициентын тэг бус утганд хүргэдэг. [3] ажилд $\sigma(T_c)/\sigma(0) = 0.121(35)$ гэж гаргасан бөгөөд энэ нь нэгдүгээр эрэмбийн фазын шилжилтийн баталгаа юм.

В. Поляковын гогцоо

КХД-т Поляковын гогцоо нь эрэмбийн параметр болж ашиглагддаг. Өөрөөр хэлбэл Поляковын

гогцооны дундаж утга тэгтэй тэнцүү, $\langle L \rangle = 0$, байвал конфайнмент фаз, дундаж утга тэг бус утгатай, $\langle L \rangle \neq 0$, байвал деконфайнмент фазад байна гэж ялгадаг. SU(2) онолд Поляковын гогцоо нь бодит утгатай байдаг бол SU(3) онолд Поляковын гогцоо нь комплекс утга авдаг. Цэвэр SU(3) онолд, критик цэг дээр конфайнмент болон деконфайнмент фазууд зэрэгцэн оршиж байдаг ба үүнээс шалтгаалж SU(3) онолд, T_c -тэй ойр (T_c -аас бага) байх температурын утганд симуляци явуулах үед деконфайнмент фазын хольц орж ирдэг. Үүнийг Поляковын гогцооны хугацааны гистограмыг байгуулснаар харж болно. Зураг 2-т харагдаж байгаа жижиг пик нь деконфайнмент фазын хольцыг харуулж байна.



Зураг 2. Поляковын гогцооны гистограм, $0.98T_c$ [4].

Харин критик цэг дээр ижил хэмжээтэй, бие биенээсээ сайн салсан, Гаусс-төст хоёр пик илэрдэг. Энэ нь конфайнмент ба деконфайнмент фазууд нь критик цэг дээр зэрэгцэн оршиж байгааг харуулдаг. SU(2) онолд Поляков гогцооны гистограм нь ямар ч температурын хувьд нэг пиктэй байдаг.

С. Поляковын гогцооны мэдрэх чадвар


Поляков гогцооны мэдрэх чадвар нь $\chi = V \cdot (\langle L^2 \rangle - \langle L \rangle^2)$ гэж тодорхойлогддог. Энд $V = N_s^3$ буюу латтисын огторгуйн эзлэхүүн юм. Энэ мэдрэх чадвар нь нөгөө талаас эрэмбийн параметр болох Поляков гогцооны флуктуацыг илэрхийлдэг. Энэ хэмжигдэхүүний хувьд нэг хоёрдугаар эрэмбийн фазын шилжилтийн үед шилжилтийн цэгийн ойролцоо пик илэрдэг. Пикийн өндөр, өргөн зэрэг хэмжигдэхүүнүүдийн хэмжээ нь finite-size scaling онолоор тайлбарлагддаг. Finite-size scaling онол нь симметр латтисын хуваарь дээр түүний өндөр $\chi_{max}(V)$ болон өргөн $\delta\beta_c(V)$ -г дараах зэрэгт функцаар

$$\chi_{max}(V) \sim V^\rho, \quad \delta\beta_c(V) \sim V^{-\sigma} \quad (4)$$

гэж таамагладаг ба пикийн байрлал $\beta_c(V)$ нь $\beta_c(V) - \beta_c(\infty) \sim V^{-\sigma}$ болж шилждэг [5]. Нэгдүгээр эрэмбийн шилжилтийн хувьд эдгээр зэргүүд нь огторгуй нь d гэсэн хэмжээтэй үед $\rho = \sigma = d$ байна гэж таамагладаг. Хоёрдугаар эрэмбийн шилжилтийн хувьд finite-size scaling нь $\rho = \gamma/\nu$, $\sigma = 1/\nu$ (γ ба ν нь стандарт критик экспонент) гэж таамагладаг бөгөөд эдгээрийн утга нь d гэсэн утгыг тооцдог нэгдүгээр эрэмбийнхээс бага байдаг.

3-н хэмжээст Ising моделийн хувьд энгийн хоёрдугаар эрэмбийн шилжилттэй бөгөөд жишээлбэл ν ба η экспонентуудын хувьд сайн мэдэх дахин нормчлолын группын үр дүн нь $\gamma/\nu = 2 - \eta = 1.969(5)$ ба $1/\nu = 1.590(1)$ гэсэн үр дүнг өгдөг ба өргөтгөсөн finite-size scaling баталгаа нь эдгээр утгуудтай таардаг буюу өөрөөр хэлбэл, $\rho = 1.98(2)$ байдаг.


$N_t = 4$ үед, огторгуйн эзлэхүүн өөр өөр хэмжээтэй үед Поляков гогцооны мэдрэх чадварыг SU(2) ба SU(3) онолуудад тус тус зурсныг Зураг 3-т харууллаа. Зургаас харахад SU(2) онолын хувьд латтисын огторгуйн эзлэхүүн өөрчлөгдөхөд пикийн байрлал бараг өөрчлөгдөхгүй байхад, SU(3) онолын хувьд эзлэхүүнээс хамаарч пикийн байрлал шилжиж байгаа нь харагдаж байна. Иймээс SU(3) онолын хувьд β_c -ийн утгыг хязгааргүй том эзлэхүүнтэй байх хязгаар руу Тэгшитгэл 1-ийг ашиглан экстраполяци хийдэг.



Зураг 3. Поляковын гогцооны мэдрэх чадвар. Дээд: SU(2) [6], Доод: SU(3) [7].

Д. Энергийн нягт ба нуугдмал дулаан

Нэгдүгээр эрэмбийн фазын шилжилт болох цэг дээр хоёр фаз хугацааны нэг агшинд нэгэн зэрэг оршин байдаг гэдгийг бид өмнө дурдсан. Тэдгээрийн хоорондын балансыг хадгалахын тулд энэ хоёр фазад даралт нь ижил байх ёстой. Харин нөгөө талаас энергийн нягтууд нь эдгээр хоёр фазад ялгаатай байх ёстой. Энэ энергийн нягтын ялгааг **нуугдмал дулаан** гэж нэрлэдэг. Энэ хэмжигдэхүүн нь нэгдүгээр эрэмбийн шилжилтийг тодорхойлдог хамгийн чухал физик хэмжигдэхүүнүүдийн нэг юм. Фазын шилжилтийн үед авч үзэж байгаа энэ хэмжигдэхүүн нь шинэ материйн төлөв үүсгэхийн тулд системд хэр их энерги шаардлагатай вэ? гэдгийг илэрхийлдэг. SU(2) онолд энэ хэмжигдэхүүн нь тэг утгатай байдаг бол SU(3) онолд тэг бус утгатай байна. Нуугдмал дулаан нь критик цэг дээрх энергийн нягтын тасралтаар илэрхийлэгдэнэ. Зураг 3-т SU(3) онолын энергийн нягт темпеартураас хамаарах хамаарлыг харууллаа. Зургаас критик температур дээр энергийн нягтын тасралт ажиглагдаж байгаа нь харагдаж байна. Энэ зөрөөг нуугдмал дулаан гэж нэрлэдэг.



Зураг 4. Энергийн нягт температураас хамаарах хамаарал [9].

Нуугдмал дулааныг

$$\Delta\epsilon = \frac{1}{4} \frac{1}{N_s^3 N_\tau} \frac{12}{g_0} \beta(g_0) \Delta < P > \quad (5)$$

гэж тооцоолно. Энд $P = P_t + P_s$, $\beta(g_0) = a \frac{\partial g_0}{\partial a}$ буюу β -функц. β -функцыг оруулвал

$$\Delta\epsilon = \frac{1}{4} \frac{1}{N_s^3 N_\tau} \frac{12}{g_0} \left(\frac{11}{(4\pi)^2} + \frac{102^4}{4\pi} g_0^2 + \dots \right) \Delta < P > \quad (6)$$

гэсэн хэлбэртэй болно [8]. Эндээс плакетын тасралтыг хэмжсэнээр энергийн нягтын

тасралтыг тооцоолж болно гэдэг нь харагдаж байна.

III. ФИЗИК ҮР ДҮНГҮҮДИЙН ХАРЬЦУУЛАЛТ

А. Холбоосын тогтмол

Ижил температуртай үед SU(3) онолын холбоосын тогтмол $g^2(T)$ нь SU(2) онолынхтой харьцуулахад бага утгатай байдаг. Жишээлбэл [10] ажилд SU(3)-т $g^2(2T_c) = 2.0$ байхад SU(2)-т 2.7 байна гэж харуулсан байна. Үүнтэй аналогоор латтис нэгжээр илэрхийлэгдсэн хэмжигдэхүүнийг физик нэгж рүү шилжүүлэхэд ашиглагддаг scaling function нь ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл хөндөх онолын β -функцын scale параметр нь SU(3)-т SU(2)-ынхоос бага зэргийн их байдаг. Scale параметрыг SU(2) онолд $\Lambda = 100$ МэВ гэж авч үздэг бол [11] ажилд SU(3) онолын Λ парметрыг 247 (16) МэВ гэж тооцсон байна. Иймээс $g^2 = \frac{2N}{\beta}$ гэсэн хамаарлын дагуу ижил температурт харгалзах латтис холбоосын тогтмол β -ын утга SU(3) онолд их, SU(2) онолд бага утгатай байдаг. Үүнийг Хүснэгт 1-ээс харж болно.

Хүснэгт 1. $N_\tau = 8$ үед ижил температурт харгалзах SU(2) ба SU(3) онолын латтис холбоосын тогтмол.

Температур, T_c	Холбоосын тогтмол (β)	
	SU(2)	SU(3)
$0.75T_c$	2.435	5.895
$0.86T_c$	2.475	5.973
$0.98T_c$	2.515	6.050
$1.13T_c$	2.560	6.143
$1.29T_c$	2.600	6.233


В. Глюоны урсгалын хоолойн өргөн

Конфайнмент фазад, температур ихсэхэд урсгалын хоолойн өргөн ихэсдэг. Харин декофайнмент цэгээс эхлэн температур ихсэхэд өргөн буурдаг. Энэ нь конфайнмент фазад холбоосын тогтмол $g^2(T)$ бага байхад өргөн их, $g^2(T)$ их байхад өргөн бага байна гэсэн үг. Харин деконфайнмент фазад $g^2(T)$ -ын бага утганд урсгалын хоолойн өргөний бага утга харгалзана гэсэн үг юм. Үүнийг илүү ойлгомжтой байхаар Хүснэгт 2-т харуулав. Иймээс SU(2) ба SU(3) онолуудын хувьд, конфайнмент фазад, ижил температурт, кваркууд ижил зайд байхад урсгалын хоолойн өргөн SU(2)-т бага, SU(3)-т их байна.

Хүснэгт 2. Урсгалын хоолойн өргөн ба холбоосын тогтмолын хамаарал.

Фаз	$g^2(T)$	Өргөн (D^2)
Конфайнмент	Их	Бага
	Бага	Их
Деконфайнмент	Их	Их
	Бага	Бага

Харин деконфайнмент фазад байхад, SU(2)-т өргөн их, SU(3)-т бага байна гэж таамаглаж байна. Бид конфайнмент фазад байх үед, SU(2) ба SU(3) онолуудын хувьд өргөний харьцуулалт хийлээ. Зураг 5-аас харахад температур $T = 0.98T_c$ утганд, кварк хоорондын зай $R\sqrt{\sigma} \approx 1.4$ (SU(2): $R\sqrt{\sigma} = 1.41$, SU(3): $R\sqrt{\sigma} = 1.45$) байх үед урсгалын хоолойн өргөн нь SU(2) онолд $D^2\sigma = 0.43$ байхад SU(3) онолд $D^2\sigma = 1.16$ байна.




Зураг 5. Урсгалын хоолойн өргөн кварк хоорондын зайнаас хамаарах хамаарал. Дээд: SU(2) $40 \times 16^2 \times 8$ хэмжээтэй латтис [12], Доод: SU(3), $48^3 \times 8$ хэмжээтэй латтис [13].

С. Таталцлын коэффициент

Таталцлын коэффициент (σ) температур ихсэхэд буурдаг. Өөрөөр хэлбэл $g^2(T)$ бага байхад таталцлын коэффициент бага байна гэж үзнэ. Ижил температуртай байхад SU(3) онолд $g^2(T)$ бага байдаг учраас SU(2) онолын таталцлын коэффициент SU(3)-ынхаас их байна гэж


таамаглаж болно. Гэтэл Зураг 6, 7-оос харахад эсрэгээрээ байна. Өөрөөр хэлбэл Зураг 6-аас харахад ижил $T = 0.98T_c$ үед, SU(2) онолд $\frac{\sigma(T)}{\sigma(0)} = 0.059$ байхад, SU(3) онолынх 0.435 байна. Мөн Зураг 7-аас харахад, бүх температурын утганд SU(3) онолын таталцлын коэффициент SU(2) онолынхоос их байгаа нь харагдаж байна.



Зураг 6. Таталцлын коэффициент температураас хамаарах хамаарал. Дээд: SU(2) $40 \times 16^2 \times 8$ хэмжээтэй латтис [12], Доод: SU(3), $48^3 \times 8$ хэмжээтэй латтис [14].


Д. Кварк хоорондын потенциал

Кварк хоорондын потенциалын температураас хамаарах хамаарал нь дээрх таталцлын коэффициенттэй ижил байдаг. Тиймээс SU(2) ба SU(3) онол дахь тоон утгууд нь таталцлын коэффициенттэй ижил хамааралтай байна гэж таамагласан. Зураг 8-д SU(2) ба SU(3) онолын тохиолдолд потенциал кварк хоорондын зайнаас хамаарах хамаарлыг хэд хэдэн температурын утганд зурсныг харуулж байна. Харьцуулалт хийхдээ SU(3)-ын тохиолдолд $0.99T_c$ -ын утгыг сонгож авсан ба харин SU(2)-ын тохиолдолд



Зураг 7. Таталцлын коэффициент температураас хамаарах хамаарал. Ногооноор $SU(2)$ -ын, цэнхэрээр $SU(3)$ -ын үр дүнг тус тус тэмдэглэсэн [15].

$0.98T_c - 1.13T_c$ интервалыг сонгон авч хооронд нь харьцуулсан. Бид $SU(2)$ онолоос гарсан үр дүнг температурын нэгж рүү шилжүүлэн харьцуулсан. Харьцуулсан үр дүнг Хүснэгт 3-т үзүүлсэн ба эндээс харахад $SU(2)$ онолын потенциалын утга $SU(3)$ -ынхаас бага байгаа нь харагдаж байна.



Зураг 8. Кварк хоорондын потенциал тэдгээрийн хоорондох зайнаас хамаарах хамаарал. Температурын хэд хэдэн утганд зурсан. Дээд: $SU(2)$ $32 \times 12^2 \times 6$ хэмжээтэй латтис [16], Доод: $SU(3)$ $32^3 \times 6$ хэмжээтэй латтис [3].

Хүснэгт 3. $SU(2)$ ба $SU(3)$ онолоос гарах кварк хоорондын потенциалын тоон утгууд.

RT	$SU(2)$	$SU(3)$
	$V(R,T)/T$ $0.98T_c - 1.13T_c$	$V(R,T)/T$ $0.99T_c$
0.67	4.88 – 4.11	6.61
1.00	5.13 – 4.20	6.91
1.67	5.42 – 4.24	7.22
2.00	5.55 – 4.27	7.25

IV. ДҮГНЭЛТ

Энэ ажлаар бид кваркуудын хооронд орших глюоны урсгалын хоолойн конфайнмент төлвөөс деконфайнмент төлөв рүү шилжих фазын шилжилтийг илэрхийлдэг $SU(2)$ ба $SU(3)$ бүлэгт суурилсан онолуудыг судаллаа.

Онолын хувьд ямар ямар ялгаанууд байдгийг судлан, тэдгээрээс гарах физик үр дүнгүүдийн тоон утгын ялгааг өмнө хийгдсэн ажлуудыг харьцуулан тогтоолоо. Бид урсгалын хоолойн өргөн, таталцлын коэффициент, кварк хоорондын потенциал зэрэг хэмжигдэхүүнүүдийг харьцуулсан. Ингэхдээ эхлээд, тухайн хэмжигдэхүүний температур, холбоосын тогтмолоос хамаарах хамаарлаас $SU(2)$ ба $SU(3)$ онолуудын үр дүнгүүдийн тоон утгууд ямар хамааралтай байхыг таамагласан. Дараа нь бид өмнө хийгдсэн ажлуудын үр дүнгүүдийг харьцуулж, энэ таамаглалаа шалгахад конфайнмент фаз дахь урсгалын хоолойн өргөний таамаглал тохирч байсан боловч таталцлын коэффициент болон потенциалын үр дүн эсрэгээрээ байсан. Харьцуулсан үр дүнгээс харахад, бүх хэмжигдэхүүнүүдийн хувьд $SU(2)$ онолын үр дүн $SU(3)$ -ынхаас тоон утгаараа бага байсан.

НОМЗҮЙ

- [1] G. Boyd, J. Engels, F. Karsch, E. Laermann, C. Legeland, M. Luetgemeier and B. Petersson, Thermodynamics of $SU(3)$ lattice gauge theory, Nucl. Phys. B469, 419-444, (1996).
- [2] Y. Iwasaki, K. Kanaya, et. al., Finite-temperature phase transition of $SU(3)$ gauge theory on $N_\tau = 4$ and 6 lattices, Phys. Rev. D46, 4657-4667, (1992).
- [3] O. Kaczmarek, F. Karsch, E. Laermann and M. Luetgemeier, Heavy Quark Potentials in

- Quenched QCD at High Temperature, Phys.Rev. D62, 034021, (2000).
- [4] P. Bicudo, N. Cardoso and M. Cardoso, Pure gauge QCD flux tube and their widths at finite temperature, arXiv:1702.03454 [hep-lat], (2017).
- [5] M. Fukugita, M. Okawa and A. Ukawa, Finite size scaling study of the deconfining phase transition in pure SU(3) lattice gauge theory, Nucl. Phys. B337 181-232, (1990).
- [6] J. Engels, T. Scheideler, The calculation of critical amplitudes in SU(2) lattice gauge theory, Nucl. Phys. B539 557-576, (1998).
- [7] Bernd A. Berg and Hao Wu, SU(3) deconfining phase transition with finite volume corrections due to a confined exterior, Phys. Rev. D88 074507, (2013).
- [8] H. J. Rothe, Lattice gauge theories: An introduction, World scientific, (2005).
- [9] T. Celik, J. Engels and H. Satz, The order of deconfinement transition in SU(3) Yang Mills gauge theory, Phys. Lett. 125B 411-414 (1983).
- [10] F. Karsch, E. Laermann and M. Lutgemeier, Three-Dimensional SU(3) gauge theory and the Spatial String Tension of the (3+1)-Dimensional Finite Temperature SU(3) Gauge Theory, Phys. Lett. B346 94-98, (1995).
- [11] R. G. Edwards, U. M. Heller and T. R. Klassen, Accurate scale determinations for the Wilson gauge action, Nucl. Phys. B517, 377-392, (1998).
- [12] Ch. Sodbileg, G. Enkhтuяа, E. Laermann and P. Battogtokh, Width and string tension of the flux tube at high temperature, J. Phys G: Nuclear and Particle physics, 45, (2017).
- [13] P. Bicudo, N. Cardoso and M. Cardoso, Pure gauge QCD flux tube and their widths at finite temperature, arXiv:1702.03454 [hep-lat], (2017).
- [14] N. Cardoso and P. Bicudo, Lattice QCD computation of SU(3) string tension critical curve, Phys. Rev. D85 077501, (2012).
- [15] P. Bicudo, The QCD string tension curve, the ferromagnetic magnetization, and the quark-antiquark confining potential at finite temperature, Phys. Rev. D82 034507, (2010).
- [16] Ч. Содбилэг, Э. Лаэрманн, Г. Гантулга, Г. Энхтуяа, Кварк-антикваркийн үүсгэх глюоны орны тархалтын симуляцыг GPU-ээр хурдасгасан үр дүнгээс, ФТХ-ийн Бүтээл №42 10-25, (2015).

Поликристаллын дифракцийн үр дүнг боловсруулах

Ж.Даваасамбуу*

МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Физикийн тэнхим

Байгалийн шинжлэлийн олон салбарын судалгаанд рентген цацрагийн болон нейтроны дифракцийн аргуудыг өргөн хэрэглэдэг билээ. Гэвч эдгээр дифракцийн аргын боловсруулалтыг зөвхөн монокристаллын болон нунтгийн дифракцийн хэмжилтийн тохиолдолд бүрэн хийх боломжтой. Бусад тохиолдол буюу поликристаллын дифракцийн хэмжилтийн үр дүнг саяхныг хүртэл боловсруулж чадахгүй ирсэн нь олон шалтгаантай юм. Дифракцийн туршилтын хэмжилтийн үр дүнг боловсруулах, түүнээс кристалл бүтцийн талаар мэдээллийг олж авах нь тийм ч амар биш. Поликристаллын төдийгүй монокристаллын дифракцийн өгөгдлийг боловсруулах нь төвөгтэй. Сарнисан цацрагийн эрчим бүтцийн факторын квадратад пропорциональ учир фазын тухай мэдээлэл алдагддагаас кристалл бүтцийг тодорхойлох нь онолын хувьд байнгын асуудал юм. Нөгөө талаас лабораторийн рентген төхөөрөмжийн цацрагийн эрчим нь поликристаллыг бүрдүүлэгч хөврөл (grain) бүрийн Врегтийн рефлексийг бүртгэхэд хүрэлцээтэй биш, улмаар поликристаллын хөврөл бүрийн кристалл бүтцийг тодорхойлох тухай ойлголт байхгүй. Эдгээр шалтгааны улмаас поликристаллын дифракцийн хэмжилтийн үр дүн одоог хүртэл бүрэн гүйцэд боловсруулагдахгүйгээр явж ирсэн. Хэрэв энэхүү асуудлыг бүрэн шийдвэрлэвэл тэр нь судалгааны олон салбарт шинэ мэдээллийг олж авахад чухал ач холбогдолтой.


Сүүлийн үед өндөр эрчимтэй цацрагийн үүсгүүрүүд болох синхротрон цацрагийн үүсгүүрүүд болон дифракцийн пикүүдийг олноор нь хурдан бүртгэх 2 хэмжээст CCD детекторууд бий болсон нь поликристаллын дифракцийн аргыг цааш хөгжүүлэх боломжийг олгох боллоо[1-2].

Монокристалл дээжийг ургуулах нь амаргүй, мөн судалгааны дээжүүд ихэвчлэн поликристалл бөгөөд түүнчлэн дээжүүд туршилтын явцад гадны хүчний харилцан үйлчлэлийн нөлөөгөөр поликристалл болох тохиолдол их байдаг[3-5]. Жишээлбэл органик


кристаллуудыг гэрлээр шарахад кристаллын бүтцэд өөрчлөлт орохоос гадна поликристалл хэлбэрт шилжих тохиолдол бас бий.

Энэхүү асуудлыг шийдэх үүднээс бид зарим органик хагас дамжуулагчийн хувьд поликристаллын дифракцийн хэмжилтийг оновчтой болгох зорилгоор дифракцийн пикийн давхцалын зэргийн тооцооллыг хийж гүйцэтгэлээ[6]. Поликристаллын дифракцийн пикийн давхцалын зэрэг нь хэмжилтийн үр дүнг боловсруулах гол хязгаарлалт юм. Давхцалын зэрэг 30% -аас дээш болвол хэмжилтийн үр дүнг боловсруулах бараг боломжгүй. Иймээс давхцалын зэрэг поликристалл дээжинд байгаа хөврөлийн тоо, хэмжилтийн нарийвчлал, туршилтанд ашиглаж буй рентген цацрагийн долгионы урт болон дээж-детектор хоёрын хоорондох зайнаас хэрхэн хамаарах зүй тогтолыг тогтоож туршилтын оновчтой горимыг олох нь нэг чухал ажил юм.

Энэхүү ажлын хүрээнд тетра-тиа-фулвален-хлор-анил (TTF-CA) гэж нэрлэгдэх органик хагас дамжуулагчийн хувьд поликристалл дээжний пикийн давхцалын зэрэг бусад туршилтын параметрээс хэрхэн хамаарах зүй тогтолыг тогтоов. Зураг 1-д давхцалын зэрэг дээж-детекторын хоорондох зайнаас (а), мөн тэр зай 100мм байх үед хэмжилтийн нарийвчлал болон дээжний хөврөлийн тооноос (b) хэрхэн хамаарахыг харууллаа.




* Electronic address: davaasambu@num.edu.mn



Зураг 1. Поликристаллын дифракцийн пикийн давхцалын зэрэг.

Тооцоололоос давхцалын зэрэг дээж-детекторын хоорондох зай ихсэх тусам буурч, харин хөврөлийн тоо болон хэмжилтийн нарийвчлалыг сайжруулах тусам ихсэж байгаа нь харагдаж байна.

Энэ тооцоололд тулгуурлан туршилтын параметруудийг дараахь утгатай байхаар сонгон авлаа. Үүнд давхцалын зэрэг 5%-аас хэтрэхгүй байж рентген цацрагийн долгионы урт 0.6Å , хэмжилтийн нарийвчлал 0.75Å^{-1} , дээж-детектор хоёрын хоорондох зай 100мм байхаар сонгож туршилтыг хийж гүйцэтгэлээ. Хамбургын Электроны Синхротроны Төвд (DESY) TTF-CA поликристалл дээжинд хэмжилтийг хийж гүйцэтгэн “multigrain” аргуудыг[7-9] ашиглан боловсруулалтыг хийлээ. Поликристаллын туршилтын ерөнхий бүдүүвчийг Зураг 2-т харуулав.




Зураг 2. Поликристаллын дифракцийн туршилтын схем.

Поликристалл дээжний дифракцийн хэмжилтийг боловсруулах multigrain аргын гол санаа нь параллел биш хавтгайгаас ойсон дифракцийн 2 пикийн бүлийг сонгон боломжит бүх чиглэлийн матрицийг байгуулж улмаар хэмжилтийн бүх пикийг харгалзах хөврөл бүрээр нь ангилан ялгахад оршино.


TTF-CA поликристаллын дифракцийн пикүүдийн 2 хэмжээст CCD детектор дээрх байрлалыг Зураг 3-т, мөн 2θ дифракцийн өнцөг, ϕ азимутал өнцгөөс хамаарах хамаарлыг Зураг 4-т харууллаа. Детекторын байрлал, кристалл

торын параметр, рентген цацрагийн долгионы урт зөв өгөгдсөн тохиолдолд дээрхи өнцгийн хамаарал шулуунаар зурагдах ёстой.

Хэмжилтийн эхний 2 бүл ((110), (200)) пикүүдэд тулгуурлан байж болох боломжит бүх чиглэлийн матрицийг байгуулж тэдгээр чиглэлийн матриц бүрд бүх хэмжилтийн пикийг таарах эсэхийг шалган чиглэлийн матриц бүрээр нь пикүүдийг ангилан индекслэв. Поликристаллын хөврөлүүдийн хувьд хэмжилтийн бүрэн бүтэн байдал нь 72.5%, хэмжээ нь 5 микрометр байлаа.



Зураг 3. Поликристаллын дифракцийн хэмжилт.


Зураг 4. Поликристаллын дифракцийн хэмжилтийн 2θ өнцөг ба ϕ азимутал өнцгийн хамаарал.

Туршилтаар энэ поликристалл дээжнээс бүртгэгдсэн дифракцийн пикийн тоо 10808

байсан. Энэ тооцооны үр дүнд 4 чиглэлийн матриц тус бүрт нь ойролцоогоор 1000-аас дээш

тооны дифракцийн пикүүд харгалцаж байгаа нь тогтоогдлоо. Нийт пикийн 96.8% буюу 10462 нь амжилттай индекслэгдэж 3.2% нь буюу 346 нь

индекслэгдээгүй. Эдгээр нь тодорхойлогдсон 4 чиглэлийн матрицанд хамааралгүй байна гэсэн үг юм.



Зураг 5. Поликристаллын дифракцийн хэмжилтийн үр дүнгийн боловсруулалт.

Индекслэгдсэн (10402) пикүүдийн 99.43% нь давхцалгүй харин 0.57% буюу 60 пик нь бусад хөврөлийн пикүүдтэй давхцаж байгаа нь тогтоогдов. Энэхүү тооцоог GRAINDEX, ImageD11, GrainSpotter, Cellnow программуудыг ашиглан тус бүрд нь хийсэн бөгөөд үр дүнгүүд нь хоорондоо маш сайн таарч байлаа[10]. Энэ үйлдлийн дараа 4 чиглэлийн матрицанд харгалзах хэмжилтийн үр дүнд тулгуурлан хөврөл бүрийн кристалл бүтцийг SHELXTL программын тусламжтай тодорхойлж сайжруулалтыг хийлээ. TTF-CA молекул кристаллын 4 хөврөлөөс бүрдсэн дээжийн хувьд дифракцийн хэмжилтийн үр дүнг боловсруулж хөврөл бүрээр нь ялгаж ангилан өөр өөр өнгөөр тэмдэглэснийг Зураг 5-д харуулав.

Поликристаллын хэмжилтийн хөврөл тус бүрд гарган авсан үр дүнгийн хувьд $R=2\%$ орчимд байгаа нь монокристаллын дифракцийн үр дүнгээс илүү нарийвчлалтайг харуулж байгаа бөгөөд энэ нь поликристалл дээжинд буй

хөврөлийн дифракцийн пикээс өөр гадны хэмжилтийн нөлөөлөл ороогүйтэй холбоотой юм.

Энэхүү судалгааны ажлаар поликристалл TTF-CA органик хагас дамжуулагчийн хувьд янз бүрийн хөврөлийн дифракцийн пикүүдийн давхцалын зэрэг дээж-детекторын хоорондох зай ихсэх тусам буурч, харин хөврөлийн тоо болон хэмжилтийн нарийвчлал дээшлэх тусам ихсэж байгаа зүй тогтолыг farfield болон no-overlaps программуудыг ашиглан тогтоов.

Түүнчлэн поликристалл дээжийн хэмжилтийн үр дүнг боловсруулж хөврөл тус бүрээр кристалл бүтцийг өндөр нарийвчлалтайгаар тодорхойлж болохыг харууллаа.

ТАЛАРХАЛ

Энэ судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж буй ШУТС-д талархаж байгаагаа илэрхийлье.

НОМ ЗҮЙ

- [1] H.F.Poulsen, Three-dimensional X-ray diffraction microscopy. Mapping polycrystals and their dynamics. (Springer Tracts in Modern Physics, v. 205), Berlin, 2004
- [2] S.Send, A.Aboud, N.Wiesner, M.Shokr, M.Klaus, Ch.Genzel, T.Conka-Nurdan, D.Schlosser, M.Huth, R.Hartmann, L.Strueder and U.Pietsch, J. Appl. Cryst., 49, 222-233, (2016)
- [3] J.Davaasambuu, P.Durand, S.Techert, J. Synchrotron Rad., 11, 483-489, (2004)
- [4] C.Blome, T.Tschentscher, J.Davaasambuu, P.Durand, S.Techert, J. Synchrotron Rad., 12, 812-819, (2005)
- [5] J.Hallmann, W.Morgenroth, C.Paulmann, J.Davaasambuu, Q.Kong, M.Wulff, S.Techert, J.Am.Chem.Soc., 131, 15018-15025, (2009)
- [6] S.Schmidt, Farfield Simulation Package, Risoe National Laboratory, Denmark, (2007), http://fable.sourceforge.net/index.php/Farfield_Simulation
- [7] E.M. Lauridsen, S.Schmidt, R.M.Suter and H.F. Poulsen, J. Appl. Cryst. 34, 744-750, (2001)
- [8] S.Schmidt, <http://fable.sourceforge.net/index.php/Grainspotter>
- [9] J.Wright, <http://fable.sourceforge.net/index.php/ImageD11>
- [10] H.O.Soerensen, S.Schmidt, J.P.Wright, G.B.M.Vaughan S.Techert, E.F.Garman, J.Oddershede, J.Davaasambuu, K.S.Paithankar, C.Gundlach, H.F.Poulsen, Zeitschrift f. Kristallogr., 227, 63-78, (2012).

Тамсагийн сав газрын гүний тогтоц

Б.Даариймаа*, Ц.Баатарчулуун

МУИС, ШУС, Геологи Геофизикийн тэнхим

Энэ судалгааны ажлаар Тамсагийн сав газрыг бүрдүүлэгч зарим хотгоруудын орон зайн байршил ба ерөнхий дүр төрхийг соронзон ба хүндийн хүчний судалгааны үр дүнг ашиглан тодорхойлов. Мөн зарим хотгоруудыг дүүргэгч мезо-кайнозойн насны тунамал хурдсын зузааныг хүндийн хүчний үлдэгдэл Буге гажлын урвуу бодолтоор үнэлж өмнө хийгдсэн геологи геофизикийн судалгааны үр дүнтэй харьцуулан судлав.

PACS number: 93.85.Hj, 91.60.Pn, 91.65.Ti, 92.20.Vn

I. ОРШИЛ

Эх газрын царцдас дахь гүний хотгорууд бол Монгол орны геологийн структуриудын нэг хэлбэр бөгөөд эдгээрт шатах ашигт малтмал, байгалийн хийн гол хуримтлалууд үүссэн байдаг.

Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн хучаас хурдасны зузааны талаарх анхны судалгаа бол 1982 онд тухайн үеийн ЗХУ-ын В.Я.Широков нарын судлаачид газрын тос байгалийн хий агуулах боломжтой хотгоруудын судалгаа юм. Энэ судалгаагаар А.Л.Яншина нарын судлаачид Монгол орны мезозой ба кайнозойн тектоникийн зурагт /1979/ үндэслэн Монгол орны хэмжээнд мезо-кайнозойн 13 сав газар, 59 хотгорыг ялгаж, гүнийг үнэлсэн байдаг. Мөн түүнчлэн газрын тос агуулагч хотгоруудын хүрээнд олон тооны геологи, геофизикийн цогцолбор судалгаа хийгдсэн байдаг.

Томоохон гүний хотгоруудын дотоод тогтоц, дүүргэгч тунамал хурдсын зузааныг тодорхойлох нь тухайн бүс нутгийн геологи, тектоникийн судалгаа, ашигт малтмалын орд илрүүлэх хэтийн төлөвийн үнэлгээнд ихээхэн ач холбогдолтой мэдээлэл болдог.


Энэ судалгааны ажлын хүрээнд Тамсагийн сав газрыг бүрдүүлэгч томоохон хотгоруудад хуримтлагдсан тунамал хурдсын зузааныг үнэлэх буюу талст суурь чулуулгийн гүнийг тодорхойлох зорилго тавьлаа. Судалгаанд “Хойд-Төв-Зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” сэдэвт олон улсын хамтарсан төслийн үр дүн болох Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн соронзон ба хүндийн хүчний хайгуул, судалгааны тоон өгөгдлийн сан, мезо-кайнозойн насны хурдсын талаарх судалгааны материалуудыг ашиглав.

II. БҮС НУТГИЙН ГЕОЛОГИЙН ТОГТОЦ

Тамсагийн сав газар нь Монгол орны нутаг дэвсгэрийн зүүн хэсэгт, Дорнод аймгийн нутагт байрладаг. Тус сав газар нь зүүн өмнөөсөө Нүхэт давааны, баруун талаасаа Дарьганга, Матад Баруун-Уртын өргөгдлөөр хүрээлэгдэнэ. Тус сав газар нь 330×105 км орчим талбайг хамрах ба Баянбүрд-Сүмбэрийн, Заг-Хөв нуурын, Тамсаг-Баянговийн болон Могойт-Шорвогийн хотгоруудаас тогтоно [2].

Хотгорын бүсүүд ерөнхийдөө зүүн хойш сунаж тогтсон, харьцангуй нилээд эрчимтэй шахалт, тектоникийн хагаралд өртсөн байна. Сав газрын талбайд ул суурийн чулуулаг гадаргууд илрээгүй ба Монгол орны хэмжээнд хучаас хурдас нь хамгийн зузаан байх боломжтой бүсэд хамаарна (Зураг 1).

Тамсагийн савын геологийн тогтоцод палеозойн ул суурийн дээр мезозой, кайнозойн эх газрын тунамал хурдас хучсан байх ба Шарил, Цагаанцав, Зүүнбаян, Сайншанд формаци болон неоген дөрөвдөгчийн тунамал хурдсууд тогтоогдсон байдаг [3].



Зураг 1. Тамсагийн сав газрын структурын зураг [2].

* Electronic address: daariimaa@num.edu.mn

Шарил формаци (J3sh). Матад сумаас урагш Зурт уулын орчимд тархсан янз бүрийн өнгөтэй, төрөл бүрийн хэмхдэст чулуулгаас бүрдэх ба гол төлөв улаан өнгөтэй, хөрзөнгийн барьцалдуулагч материал нь ихэнхдээ төмөр цахиураар баяжсан байдаг. Палеозойн хурдсыг үл нийцлэгээр хучиж, цэрдийн хурдсаар хучигдсан байдаг.

Цагаан цав формаци (K1cc). Харьцангуй их тархалттай, Хэрлэнгийн өргөгдөл, Матад сумын орчим Тамсагийн хөндий дэх хэсгүүдэд газрын гадаргууд гарштай, цооногийн мэдээлэлээр 2 зузаалagt хуваагддаг.

Зүүнбаян групп (K1dz). Тамсагийн савд хамгийн өргөн тархалттай бөгөөд Тамсагийн мужийн захаар болон Өвөр бүрдлийн голын өргөгдөл хэсгүүдэд газрын гадаргууд гарштай. Уг формацийн хурдас нь голын болон нуурын гарал үүсэлтэй бөгөөд элсжин, алевролит, аргиллит, нүүрс салаавчлан тогтсон.

Сайншанд формаци (K2ss). Матад, сумын зүүн өмнөд хэсэг, Халх голын эргээр газрын гадаргууд гарштай. Томоохон хөндийнүүдийн зах хэсгээр хожуу хөрзөнгийн үе байдлаар, хөндийн төв рүү элсжин, шаврын үе давамгайлсан тогтсон.

Неоген. Неогений хурдас нь төмрийн ислийн судал агуулсан карбонатлаг цементлэгчтэй элсжин, конгломерат, хар хүрэн өнгийн аргиллит, цайвар өнгийн шаварлаг хурдсаас тогтоно.

Дөрөвдөгч. Аллюви, пролюви, эллюви, делювийн элс шавар, хайрга хуримтлагдсан байдаг.

Бялхмал чулуулгийн зузаалга нь зөвхөн тектоникийн өргөгдөл хэсгүүдэд тархалттай, янз бүрийн тусгаарлагдсан хэсгүүдэд гадаргууд гарштай. Зузаалгын хурдас нь андезит, андезит-базальт, базальтаас тогтоно. Уг зузаалга нь тунамал хурдсаар хучигдаж, юрагийн хурдсыг хучиж байрладаг [2].

III. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Хүндийн хүчний орны Буге гажлын бүс нутгийн хэмжээг хамарсан зургийг зохиосноор царцдас мандлын дээд хэсгийн геологи, геодинамик, гүний тогтцын талаарх ерөнхий болон нарийвчилсан төсөөллүүдийг гарган авах боломжтой юм.

Харьцангуй бага нягт бүхий мезо-кайнозойн хурдас физик шинж чанараараа суурь чулуулгаас эрс ялгарах тул гравихайгуулын

аргаар ул чулуулгийн гүнийг тодорхойлох боломжтой юм.

Мезо-кайнозойн хурдас хүндийн хүчний Буге гажлын харьцангуй сөрөг утгаар илрэх бөгөөд геологийн материалд тулгуурлан илэрч буй гажилд геофизикийн тайлалт хийснээр хотгоруудын дотоод бүтцийн тухай төсөөллийг гаргаж авна [3].

Хүндийн хүчний Буге гажлын утгыг дараах байдлаар тодорхойлно.

$$g_B = g_{obs} - g_t + (\Delta g_L + \Delta g_{FA} - \Delta g_B + \Delta g_T)$$

g_{obs} —хүндийн хүчний ажиглагдсан утга

g_t —хүндийн хүчний онолын буюу хэвийн утга

Δg_L —өргөрөгийн засвар

Δg_{FA} —чөлөөт агаарын засвар

Δg_B —Буге засвар

Δg_T —Топо засвар

Хотгорт хуримтлагдсан тунамал хурдсыг хавтгай үеэр төлөөлүүлэн хялбарчилж хүндийн хүчний Буге гажлын тооцоог хийх нь тохиромжтой байдаг.

Тунамал хурдсын зузаан h -ыг хүндийн хүчний үлдэгдэл Буге гажил (локаль гажил) Δg , суурь чулуулаг ба тунамал хурдсын нягтын зөрүү $\Delta \sigma$ -г ашиглан дараах томъёогоор тооцоолно [7].

$$h = -\frac{1}{\alpha} \ln \left(1 - \frac{\alpha \Delta g}{2\pi G \Delta \sigma} \right)$$

Энд:


α —туришлтаар тогтоогдсон тогтмол

G —гравитацийн тогтмол

Хотгоруудыг дүүргэж буй мезо-кайнозойн хурдсын нягтын жигнэсэн дундаж утгыг өмнө хийгдсэн геологи, геофизикийн судалгааны материалд тулгуурлан 2350 кг/м^3 -ээр, палеозойн ул суурийн нягтыг 2650 кг/м^3 -ээр тус тус төлөөлүүлэн авч ул чулуулгийн гүнийг үнэлсэн болно.


IV. СУДАЛГААНЫ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол орны хэмжээн дэх Буге гажлын ажиглагдсан хамгийн өндөр утга Тамсагийн сав газар орчимд харгалзах ба $-90 \div -60 \text{ мГал}$ орчим утгатай байдаг. Энэ нь царцдасын зузааны харьцангуй бага утгаар тайлбарлагдана [1].



Зураг 2. Хүндийн хүчний Буге гажил хучаас хурдсын ижил зузааны контур.

Тамсагийн сав газрын хүндийн хүчний орны Буге гажлын зургаас харахад хүндийн хүчний гажлуудын тархалтын байрлал геологийн структур, тектоник бүсүүдийн суналын чиглэлтэй зохицож байна (Зураг 2). Тамсагийн сав газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн гравиметрийн судалгааны үр дүнгээр тодорхойлогдсон үлдэгдэл Буге гажлын (локаль орны) тархалтын зүй тогтлыг хучаас хурдсын изопакетийн зурагтай харьцуулан Зураг 3-д үзүүлэв.




Зураг 3. Тамсагийн бүсийн үлдэгдэл Буге гажлын зураг болон хучаас хурдсын изопакетийн зураг.

Тамсагийн бүсийн хэмжээнд үлдэгдэл Буге гажлын тархалтын зүй тогтол нь харьцангуй өндөр эрчимтэй, сөрөг утга бүхий тусгаарлагдсан гажлын бүсүүдээр зураглагдах бөгөөд энэ нь нягт багатай тунамал хурдас бүхий хотгоруудын орон зайн байршилтай давхцаж байна.

Үлдэгдэл Буге гажлын тархалтын зүй тогтол дахь сөрөг утга бүхий гажлын бүсийг ашиглан геофизикийн урвуу бодлого бодох замаар


хотгоруудыг дүүргэгч хучаас хурдсын зузааныг нарийвчлан үнэллээ (Зур. 4).



Зураг 4. Тамсаг-Баянговийн хотгорын гүний зүсэлт.

Урвуу бодолтын үр дүнгээс харахад Тамсаг-Баянговийн хотгор нь 3000 м орчим зузаан тунамал хурдсаар хучигдах ба үлдэгдэл Буге гажлын оронд -15 ÷ -10 мГал утгаар дүрслэгдэж байна. Энэ нь газрын тосны хайгуулын зориулалт бүхий өрөмдлөгийн үр дүнтэй тохирч байна.

Тамсагийн сав газрын соронзон гажлын тархалт нь -354 нТл -аас 220 нТл эрчим бүхий гажлаар зураглагдах бөгөөд гажлын зүй тогтлыг тухайн бүс нутгийн хагарлын систем болон мезо-кайнозойн хурдсын тархалттай харьцуулан Зураг 5-д үзүүлэв.



Зураг 5. Тамсагийн сав газрын геосоронзон гажлын зураг.

Зургаас харахад Тамсагийн сав газрын гүний хотгорууд нь геосоронзон гажлын өөрчлөлт багатай сөрөг соронзон гажлаар илэрдэг бол хотгоруудыг тусгаарлах өргөгдлүүдийн бүс (зүүн хойш чиглэл бүхий Буйр нуур, Баруун шаврын өргөгдөлүүд) нь харьцангуй өөрчлөлт бүхий эерэг соронзон гажлаар зураглагдаж байна.

V. ДҮГНЭЛТ

1. Геосоронзон орны гажил болон хүндийн хүчний орны үлдэгдэл Буге гажлын тархалт нь мезо-кайнозойн насны хурдас агуулагч хотгоруудын ерөнхий дүр төрх, байршлыг үнэлэх үндсэн шалгуур болно.
2. Хотгор тус бүрийн давхарга зүйн бүрдэл эвслүүдийг бүрдүүлэгч чулуулгийн физик шинж чанарыг тодорхойлсноор Монгол орны хэмжээнд тархсан мезо-кайнозойн хотгоруудын гүнийг нарийвчлан үнэлэх боломжтой.
3. Тамсаг-Баянговийн хотгорын хучаас хурдсын зузаан нь хүндийн хүчний үлдэгдэл гажлын урвуу бодолтоор 3000 м орчим гүнтэй тодорхойлогдсон нь геофизикийн бусад судалгааны үр дүнтэй нийцэж байна.

НОМ ЗҮЙ

- [1] Ц.Баатарчулуун, Б.Даариймаа, “Хойд-Төв-Зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн тайлан, 2017
- [2] Ж.Бямба, Д.Бат-Эрдэнэ нар, Монголын геологи ба ашигт малтмал V боть, Шатах ашигт малтмал, 2015
- [3] Арвисбаатар Н., нар, “Баруун Монголын хотгоруудын геофизикийн судалгаа” төслийн тайлан, 1996
- [4] Б.Даариймаа, Ц.Баатарчулуун, “Монгол орны тектоник хагарлын системийг геосоронзон гажлын орноор үнэлсэн дүн” Геологийн асуудлууд сэтгүүл, №473 (15), 2017
- [5] Б.Даариймаа, Ц.Баатарчулуун, “Төв Монголын атираат мужийн геосоронзон гажлын онцлог”, геологи сэтгүүл, №33, 2017
- [6] Д.Бат-Эрдэнэ, “Монголын газрын тосны савуудын геологийн тогтоц”, геологийн асуудлууд 10 (326), 103
- [7] W.M.Telford, L.P.Geldart, R.E.Sheriff, Applied Geophysics, Cambridge University Press, 1990.

Resonance states in the simple schematic two-body model

D.Dolzodmaa^{1,*}, G.Khuukhenkhuu¹, K.Katō², S.Davaa¹, A.Sarsembayeva³, M.Odsuren¹

¹ School of Engineering and Applied Sciences and Nuclear Research Center, National University of Mongolia, Ulaanbaatar 210646, Mongolia

² Nuclear Reaction Data Centre, Faculty of Science, Hokkaido University, Sapporo 060-0810, Japan

³ School of Industrial Engineering after A. Burkitbaev, Satbayev University, Almaty, 0500013, Kazakhstan

The aim of this work is to obtain resonance states in the simple schematic two-body model. We take up two-body systems, which are described by Schrodinger equation. To obtain resonance states, we apply a simple schematic potential and complex scaling method (CSM). In the CSM, the resonance wave functions are obtained as eigenstates together with bound states by carrying out the diagonalization of the complex scaled Hamiltonian. By finding eigenvalues, we can show the distribution of resonance states in the complex energy plane. As a result, we obtain 5 and 4 resonance states for $J^\pi = 0^+, 1^-$ states, respectively.

INTRODUCTION

During the last several decade resonance problems have covered an important and crucial research area in nuclear physics. Recently, it has attracted much attention that the complex scaling method (CSM) [1-2] is successfully utilized for description of many-body resonant states in light and middle mass nuclei. Although many problems have been solved so far, but further researches are required still. In this study, the complex scaling method is applied to a simple schematic two-body model [3] and its reliability is confirmed. For this purpose, several resonance states of $J^\pi = 0^+$ and 1^- partial waves are investigated using the simple schematic potential.

COMPLEX SCALING METHOD

In the last quarter century, a remarkable development in the description of resonances in quantum many-body systems has been realized through application of the CSM.

Originally, the CSM was proposed by Aguilar, Combes, and Balslev in 1971 [1]. Simon advocated this method as a direct approach of obtaining many-body resonances. The use of “direct” implies that the resonance wave functions are directly obtained with complex energy eigenvalues of the quantum many-body system by solving an eigenvalue problem of the complex-scaled Schrodinger equation, $H^\theta \Psi^\theta = E^\theta \Psi^\theta$ with a real scaling angle θ . In the CSM, we take the imaginary value $i\theta$ as a parameter of the transformation.

The CSM has been proposed to solve the resonance states in the similar way as bound state problems. In the CSM, the distance of the relative coordinate is

rotated as $r \rightarrow re^{i\theta}$ in the complex coordinate plane by introducing a real parameter θ . Therefore, the Schrödinger equation

$$\hat{H}|\Psi\rangle = E|\Psi\rangle \quad (1)$$

is rewritten as

$$\hat{H}(\theta)|\Psi^\theta\rangle = E^\theta|\Psi^\theta\rangle, \quad (2)$$

where $\hat{H}(\theta)$ and Ψ^θ are the complex scaled Hamiltonian and the wave function, respectively. $U(\theta)$ operates on a function Ψ , that is,

$$\Psi^\theta = U(\theta)\Psi(r) = e^{\frac{3}{2}i\theta}\Psi(re^{i\theta}). \quad (3)$$

The eigenvalues and eigenstates are obtained by solving the complex scaled Schrodinger equation Eq.(2). The eigenvalues of resonance states are found as $E^\theta = E_r - i\Gamma_r/2$, where E_r is resonance energy and Γ_r -width of the resonant state. More detailed explanation of the CSM is given in Refs.[1, 2]. The complex scaled Hamiltonian of inter cluster motion is given by

$$\hat{H}(\theta) = U(\theta)\hat{H}U^{-1}(\theta). \quad (4)$$

RESULTS AND DISCUSSIONS

The Hamiltonian of the present model is given as

$$H = -\frac{\hbar^2}{2\mu}\nabla^2 + V(r), \quad (5)$$

where

$$V(r) = -8.0 \exp(-0.16r^2) + 4.0 \exp(-0.04r^2). \quad (6)$$

For simplicity, we put $\frac{\hbar^2}{\mu} = 1$ (MeV fm²). This potential introduced in Ref. [3] has an attractive

* Electronic address: dolzodmaa1004@yahoo.com

pocket in a short range but a repulsive barrier at a large distance. Putting Eq.(6) in Eq.(5), we solve the Schrödinger equation (Eq.(2)). To solve the Eq. (2), we employ the Gaussian basis functions given as

$$u_i(\hat{r}) = N_i(b_i)r^l \exp\left(-\frac{1}{2b_i^2}r^2\right)Y_{lm}(\hat{r}), \quad (7)$$

where the range parameters are given by a geometric progression as $b_i = b_0\gamma^{i-1}$, $i = 1, 2, \dots, N$.

In this calculation, we apply $N = 20$ and employ the optimal values of b_0 and γ to obtain stationary resonance solutions.




Figure 3. Distribution of energy eigenvalues of the $J^\pi = 0^+$ wave. Symbols (b_1) and (r_1, r_2, r_3, r_4, r_5) represent bound and resonance solutions, respectively. We here employ scaling angle $\theta = 15^\circ$. The solid line from the origin indicates the so-called 2θ line describing the branch cut.




Figure 4. Distribution of energy eigenvalues of the $J^\pi = 1^-$ wave. Symbols (b_1) and (r_1, r_2, r_3, r_4) represent bound and resonance solutions, respectively. We here employ scaling angle $\theta = 15^\circ$. The solid line from the origin indicates the so-called 2θ line describing the branch cut.

To obtain stationary values for the parameters of resonances, we apply the so-called b and θ trajectory methods. Using a property that is b and θ trajectories should be orthogonal to each other, we can easily determine the stationary point of the resonance energy with high precision by drawing these trajectories for the obtained eigen-energies [4].

We fixed Gaussian basis function's length parameter b from 0.15 to 0.25 and θ from 5 to 25 for the θ trajectory. The b trajectory was found to be roughly a circle. The true solution for resonance energy should be inside this circle, because the b trajectory is orthogonal to the θ trajectory. Therefore, we determined resonance energy as the center of the circle.

When we plot both the b and θ trajectories, we obtain an accurate estimate of the resonance position.




Figure 1. Resonance energy eigenvalues of the $J^\pi = 0^+$ wave by drawing b and θ trajectories.




Figure 2. Resonance energy eigenvalues of the $J^\pi = 1^-$ wave by drawing b and θ trajectories.

In Tables 1 and 2, we show numerical values of the calculated bound and resonant states for the $J^\pi = 0^+$ and 1^- waves respectively, and compare to the results (left) that takes from the Ref. [5].

Table 1. Bound and resonance states energies with decay widths calculated for the $J^\pi = 0^+$ wave.

0^+ wave*		0^+ wave	
E(MeV)	State	E(MeV)	State
-1.928	Bound	-1.928	Bound
0.310- $i10^{-6}$	Resonance	0.310- $i10^{-6}$	Resonance

1.632- $i0.123$	Resonance	1.633- $i0.123$	Resonance
2.249- $i1.040$	Resonance	2.249- $i1.075$	Resonance
2.854- $i2.570$	Resonance	2.850- $i1.800$	Resonance
		3.875- $i2.575$	Resonance

* From previous data [5]

Table 2. Bound and resonance energies with decay widths calculated for the $J^\pi = 1^-$ state.

1^- wave*		1^- wave	
E(MeV)	State	E(MeV)	State
-0.675	Bound	-0.675	Bound
1.171- $i0.005$	Resonance	1.171- $i0.005$	Resonance
2.031- $i0.489$	Resonance	2.018- $i0.493$	Resonance
2.832- $i1.199$	Resonance	2.830- $i1.510$	Resonance
3.934- $i1.788$	Resonance	3.655- $i2.500$	Resonance

* From previous data [5]

It can be seen that from Tables 1 and 2, two calculated results are similar to each other.

SUMMARY

In this study, we employed the simple potential model which gives a bound and several resonance states for $J^\pi = 0^+$ and 1^- waves. Present calculated results are compared with the previous calculated result and we obtained both results are similar to each other.

REFERENCES

- [1] Y.K. Ho, Phys. Rep.99,1(1983).
- [2] T. Myo, Y. Kikuchi, H. Masui, K. Katō, Prog. Part. Nucl.Phys. 79, 1 (2014).
- [3] A. Csótó, B. Gyarmati, A. T. Kruppa, K. F. Pál, and N. Moiseyev, Phys. Rev. A 41, 3469 (1990).
- [4] Sh. Aoyama, T. Myo, K. Katō, K. Ikeda, Prog. Theor.Phys. 116, 1 (2006).
- [5] M. Odsuren, K. Kato, M. Aikawa, Nucl. Data Sheets 120, 126 (2014).

Максвеллийн тэгшитгэлийн, өөрөө цуглуулагч оптик керр орчинд асимптот бөхөх гэрлийн соронзон долгио шийд. Түүний зарим хялбар хэрэглээ.

Г.Очирбат^{1*}, О.Нямсүрэн², Д.Улам-Оргих¹

¹ Физикийн тэнхим, Шинжлэх ухааны сургууль, МУИС

² Шинэ Монгол Технологийн дээд сургууль

I. УДИРТГАЛ

Оптик холбооны багаж бүтээх зорилттой холбогдулан шугаман биш үе бүхий долгио хөтлөгчөөр гэрлийн долгио тарах асуудлыг судлаачид аль эртнээс сонирхсоор иржээ. Бид харин шугаман биш үе буюу илтсээр гэрлийн соронзон ба цахилгаан долгио тарах бодлого бодоход зориулан нилээд өвөрмөгц арга зүй боловсруулсан билээ[1-3].

Хавтгай дээр татсан тэнхлэг дагуу хавтгай долгио мэт, харин хавтгайд ортогональ тэнхлэгийн координатаас триваль биш хамааралтай соронзон долгионы оронг дараах хэлбэртэй дүрсэлдэг.

$$E_x = iAe^{i\Phi_A}\varphi, \quad E_z = e e^{i\Phi_e}\varphi, \quad H_y = h e^{i\Phi_h}\varphi, \quad \varphi = \exp(-i\omega t + k_0 \beta x)$$

Үүнд $A > 0, e > 0, h < 0, \quad k_0 = \omega / c, \beta$ – рефракцийн тогтмол.

Гэрлийн соронзон долгионы орон дахь өөрөө цуглуулагч оптик керр орчины диэлектрикийн функц:

$$\epsilon = \epsilon + A^2 + e^2$$

Үүнд ϵ -диэлектрикийн тогтмол. Бид максвеллийн тэгшитгэлийг бодохдоо юуны урьд түүний хоёр анхны интегралыг ашиглан диэлектрикийн функцийн координатаас хамаарах хамаарлыг олох зорилго тавьдаг; оронгийн амплитуд бүр диэлектрикийн функцээр илэрхийлэгддэг болохоор энэ нь долгионы оронг зураглах нэгэн хувилбар болж чаддаг. Оронгийн амплитуд бүр диэлектрикийн функцээр дараах байдлаар илэрхийлэгддэг

$$h^2 = \frac{e}{2\beta^2 - e} \frac{e^2 - \epsilon^2 - 2cnst}{2}, \quad A^2 = e - \epsilon - \frac{\beta^2}{e^2} h^2, \\ e^2 = \frac{\beta^2}{2\beta^2 - e} \frac{e^2 - \epsilon^2 - 2cnst}{2e} \quad (1)$$

Диэлектрикийн функцээс координатаар авсан уламжлал:

$$\frac{de}{dz} = \frac{(e - 2\beta^2)}{e/2 + e^2} Ah \cos \Delta\Phi, \quad \text{где } \Delta\Phi = \Phi_e - \Phi_A \quad (2)$$

$$\frac{1}{2} Ah \sin \Delta\Phi = c0 \quad (3)$$

(1) ба (3) ийн тусламжтайгаар (2) нь диэлектрикийн функцийн координатаас хамаарах хамаарлыг тодорхойлох тэгшитгэл болж хувирна. Энэ хамаарал нь

$$z - z_0 = \int_{e_0}^e \frac{(\frac{e}{2} + e^2) de}{(e - 2\beta^2) Ah \cos \Delta\Phi} \quad (4)$$

Бид энэ битүүлэг интеграл шийдийг $\beta^2, 2cnst, c0$ гурван параметраас хамааруулан дэлгэрэнгүй шинжилсэн болно[1-3].

II. АСИМПТОТ БӨХӨХ СОРОНЗОН ДОЛГИО ШИЙД

(1) ийг ажиглахад $e \rightarrow \epsilon$ хязгаарт $A^2 \rightarrow 0, h^2 \rightarrow 0$ болохын тулд $2cnst = 0$ байх нь мэдэгдэнэ. Бас (3) аас харахад $c0 = 0$ болохын тулд

$$\sin \Delta\Phi = 0 \quad \text{буюу} \\ \cos \Delta\Phi = \pm 1 \quad (5)$$

(1) илэрхийллүүдийн шинжилгээнээс үзэхэд $A^2 \geq 0$ ба $h^2 \geq 0$ нөхцөлд $e \rightarrow \epsilon$ хязгаар үүсэх боломж зөвхөн $\beta^2 \geq \epsilon$ тохиолд e хэмжигдүүн $[\epsilon, \theta]$ завсарт тодорхойлогдсон байхад л гарч ирдэг. Үүнд

$$\theta = \frac{3}{4} \beta^2 + \sqrt{\frac{9}{16} \beta^4 - 0.5 \beta^2 \epsilon} \quad (6)$$

$[\epsilon, \theta]$ завсрын доод хил болох ϵ цэг нь $A^2 h^2$ функцийн хоёрдугаар эрэмбийн тэг цэг, харин дээд хил болох θ цэг нь нэгдүгээр эрэмбийн тэг цэг мөн гэдгийг цохон тэмдэглэе.

Анхны утгын бодлогын (4) шийд интеграл дорх илэрхийлэл дэх Ah функцийн араншингаас ноцтой хамаарах тул тодорхой төсөөлөл өгөхийн

* Electronic address:

тулд бид энэ функцийн явцыг график 1-д харуулав.




График 1. $A^2 h^2$ функцийн график. Параметрууд: $\varepsilon = 2.6, \beta^2 = 2.95$ Тодорхойлолтын муж: $(\varepsilon, \theta) = (2.6, 3.24214)$. Функци $e = \xi = (4\beta^2 - \varepsilon)/3 = 3.0667$ - цэг дээр максимумтай. $e = \varepsilon = 2.6$ цэг бол энэ функцийн хоёрдугаар эрэмбийн тэг цэг мөн.

Анхны утгын бодлогын (4)-шийд $\cos \Delta\Phi = \pm 1$ ийн тэмдэгийн анхны сонголтоос хамаарч асимптот бөхөх долгио тарах хоёр өөр горимыг дүрсэлнэ.

1R. $\cos \Delta\Phi = -1$ тохиол. 0Z тэнхлэгийн сөрөг чигт диэлектрикийн функц анхны e_0 утгаасаа эхлэн өссөөр хамгийн их θ утгадаа хүрчихээд цааш монотонно буурсаар ε нутга руу эмүүлнэ. Энэ тохиолд ярьсан зүйлийг ойлгомжтой болгохын үүлнээс диэлектрикийн функцийн координатаас хамаарах хамааралыг харуулсан жишээ гаргая. График 2-г үзнэ үү.




График 2. $\alpha(z)$ функцийн график. $\cos \Delta\Phi = -1, \varepsilon = 2.6, \beta^2 = 2.95$. Диэлектрикийн функцийн утгуудын муж: $(\varepsilon, \theta) = (2.6, 3.24214)$. Анхны утга: $(z_0, e_0) = (0, 2.8)$. 0Z тэнхлэгийн сөрөг чиглэлд диэлектрикийн функц анхны e_0 утгаасаа эхлэн өссөөр хамгийн их θ утгадаа хүрчихээд цааш буурсаар ε утга руу тэмүүлнэ.

2R. $\cos \Delta\Phi = +1$ тохиол. 0Z тэнхлэгийн сөрөг чиглэлд диэлектрикийн функц анхны e_0 утгаасаа эхлэн үргэлж буурсаар ε утга руу тэмүүлнэ. 3 графике үзнэ үү




График 3. $\alpha(z)$ функцийн график. $\cos \Delta\Phi = +1, \varepsilon = 2.6, \beta^2 = 2.95$. Анхны утга: $(z_0, e_0) = (0, 3.0816)$. 0Z тэнхлэгийн сөрөг чиглэлд диэлектрикийн функц анхны e_0 утгаасаа эхлэн бууран буурсаар ε утга руу тэмүүлнэ.

III. ГАДАРГУУН ДОЛГИО

Асимптот бөхөх соронзон долгио шийдийг диэлектрик ба өөрөө цуглуулагч керр орчинхоёрын заагт тохиолдох гадаргуун долгионы бодлогод хэрэглэж болно. ($z > 0$) шугаман диэлектрик орчин ба ($z < 0$) өөрөө цуглуулагч керр орчин хоёрын ($z = 0$) зааг хавтгай дагуу тарах гэрлийн соронзон долгио байж болох бүх нөхцөлийг хоёр орчны диэлектрикийн тогтмол $\varepsilon_1, \varepsilon$ ба рефракцийн тогтмол β гэсэн гурван параметраас хамаруулан илрүүлэх зорилт тавья. Энэ зорилгын үүднээс диэлектрикийн функц ($z = 0$) зааг хавтгай дээрх e_0 утгаасаа эхлэн ($z < 0$) өөрөө цуглуулагч керр орчны гүн тийш хувьсахдаа яваандаа ε утга руугаа тэмүүлэх боломжийг судлая. Шугаман орчинд $z \rightarrow \infty$ хязгаарт бөхөх соронзон долгио байх нөхцөл нь $\varepsilon_1 < \beta^2$ мөн гэдгийг юуны урьд тэмдэглэе.

Заагийн нөхцөл ашиглахад $\varepsilon_1, \varepsilon, \beta^2$ параметрууд ба зааг хавтгай дээрх өөрөө цуглуулагч керр орчны диэлектрикийн функцийн утга e_0 эдгээр дөрвөн хэмжигдүүнээр интегралчлалын тогтмол илэрхийлэгдэнэ.

$$2cnst = -\varepsilon^2 + e_0^2 - \frac{2(2\beta^2 - e_0)(e_0 - \varepsilon)}{e_0((- \varepsilon_1 + \beta^2)/\varepsilon_1^2 + \beta^2/e_0^2)}$$

$2cnst = 0$ гэж эндээс β^2 г бусад хэмжигдүүнээр нь илэрхийлбэл

$$\beta^2 = \frac{\varepsilon_1 e_0^2 (\varepsilon - 2\varepsilon_1 + e_0)}{-3\varepsilon_1^2 e_0 + e_0^3 + \varepsilon (\varepsilon_1^2 + e_0^2)} \quad (7)'$$

Хэрвээ бид

$$x_0 = e_0 / \varepsilon, \quad a = \varepsilon_1 / \varepsilon, \quad \sqrt{2}r = \beta^2 / \varepsilon, \quad \theta r = \theta / \varepsilon \quad (8)$$

гэж тэмдэглэвэл (7)' нь

$$v2r = \frac{ax_0^2(1-2a+x_0)}{-3a^2x_0+x_0^3+(a^2+x_0^2)} \quad (7)$$

Түүнчлэн гадаргуун соронзон долгио оршин байх

$$\varepsilon_1 < \beta^2, \quad \varepsilon < \beta^2, \quad \varepsilon < \varepsilon_0 < \theta \quad (8)'$$

нөхцөлүүд нь

$$a < v2r, \quad 1 < v2r, \quad 1 < x_0 < \theta r \quad (8)$$

хэлбэртэй бичигдэнэ. Үүнд

$$\theta r = \frac{3}{4}v2r + \sqrt{\frac{9}{16}v2r^2 - 0.5v2r} \quad (9)$$

Тэгэхлээр одоо $\varepsilon_1, \varepsilon$, β^2 параметруудын өгөгдсөн утгад (8) нөхцөлүүдтэй нийцэх диэлектрикийн функцийн, зааг хавтгай дээрх, x_0 утга олдохуу олдвол эдгээр параметруудаар яаж тодорхойлогдох вэ гэсэн асуултанд хариулах л үлдлээ. Шинжилгээнд (7) илэрхийллийн полюс x_r ийн байршил a - параметрийн утгаас хамаарах хамаарал чухал баримжаа болж өгөв. x_0 ийн утгын эерэг мужид полюс үүсгэж чадах a -параметрийн хамгийн бага утга:

$$a0 = 0.847487$$

байдагтай холбогдуулан a -параметрийн утгуудыг

$$0 < a < a0, \quad a0 \leq a < 1, \quad a \geq 1$$

3 мужид хувааж муж тус бүрд шинжилгээ үйлдэв. Үүнээс эхний хоёр мужид наад зах нь $v2r > 1$ нөхцөл хангагдахгүй байв. (7) илэрхийллийн полюс $x_r \geq 1$ байлаг сүүлчийн мужийг шинжлэхэд $x_0 \leq \theta r$ нөхцлийг хангах x_0 ийн утгын доод хязгаар:

$$x01 = 3a/4 + \sqrt{(3a/4)^2 - 5a} \quad (10)$$

гэж тогтоогдов. Энэ хязгаарын утгад харгалзах $v2r$ ийн утга өөрөө a тай тэнцэнэ. Энэ $x01$ утга нь a -параметрийн тухайн утгад харгалзах x_r полюсд ойрхон, зүүн талд нь байршина. Харин x_r полюс өөрөө, a -параметрийн утгаар, дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$x_r = -\frac{1}{3} - \frac{-1-9a^2}{3(-1-27a^2+3\sqrt{3}\sqrt{a^2+18a^4-27a^6})^{1/3}} + \frac{1}{3}(-1-27a^2+3\sqrt{3}\sqrt{a^2+18a^4-27a^6})^{1/3} \quad (11)$$

(8) нөхцөлүүдийг хангах x_0 -ийн утгуудын муж:

$$(x01, x02), \quad \text{үүнд } x02 = x_r$$

Үүнтэй уялдан, (8) нөхцөлүүдийг хангах, $v2r$ -ийн утгуудын муж: (a, ∞) болно.

x_0 ийн авч болох утгуудын доод ба дээд хязгаар $x01$ ба $x02$ тус бүр a -параметрийн утгаас хамаарах байдлыг график 4-т үзүүлбээс




График 4. График 4-өөс харахад зааг хавтгай дээр диэлектрикийн функцийн авч болох утгуудын мужийн хэмжээ нь a -параметрийн утга ихсэхийн хирээр өргөсдөг, харин $a \rightarrow 1$ хязгаартаа тэг болдог байна. Энэ нь $\varepsilon_1 = \varepsilon$ байхад гадаргуун соронзон долгио үүсэхгүй, харин a ийн утга 1 ээс ялимгүй их болоход л x_0 -ийн авч болох утгын маш нарийханмуж бий болно, үүнтэй уялдан $v2r$ хэмжигдүүн энэ маш нарийхан завсарт a -аас эхлэн хязгааргүй хүртэл утга авч болно. Ерөөс аль ч a ($a > 1$) -д $v2r$ ийн зөвшөөрөгдөх утгуудын мужийн доод хязгаар $v2r = a$ өөрөө зөвшөөрөгдөх утга биш ээ.

Яригдсан зүйлээс дараах дүгнэлт гарна. ε_1 диэлектрикийн тогтмолтой диэлектрик, ε диэлектрикийн тогтмолтой өөрөө цуглуулагч керр орчин хоёрын зааг хавтгай дагуу тарах гадаргуун соронзон долгио байж болох ерөнхий нөхцөл нь $a > 1$ (буюу)

$$\beta^2 > \varepsilon_1 > \varepsilon \quad (12)$$

Гадаргуун соронзон долгионы бодлогод, бүр анхнаасаа, $\varepsilon_1 / \varepsilon$ харьцаа ба зааг хавтгай дээрх ε_0 утгаар β^2 -г тодорхойлох зорилго тавигддаггүй байж таараа, харин өгөгдсөн $\varepsilon_1 / \varepsilon$ харьцаа ба рефракцийн тогтмолын өгөгдсөн β утгаар зааг хавтгай дээрх ε_0 утгыг олох шаардлага үүсэх нь мэдээж. Үүнтэй холбогдуулан $a > 1$ ба $v2r \in (a, \infty)$ нөхцөлд $x_0 = \varepsilon_0 / \varepsilon$ -ийг a ба $v2r$ ээр тодорхойлох томъёо толилуулъя.

$$\begin{aligned}
x_0 = & -\frac{-a+2a^2+v2r}{3(-a+v2r)} - (2^{1/3}(-9a^2v2r(-a+v2r)-(-a+2a^2+v2r)^2))/ \\
& (3(-a+v2r)(2a^3-12a^4+24a^5-16a^6-6a^2v2r+24a^3v2r-78a^4v2r+54a^5v2r+ \\
& 6av2r^2-12a^2v2r^2+108a^3v2r^2-54a^4v2r^2-2v2r^3-54a^2v2r^3+ \\
& \sqrt{((2a^3-12a^4+24a^5-16a^6-6a^2v2r+24a^3v2r-78a^4v2r+54a^5v2r+ \\
& 6av2r^2-12a^2v2r^2+108a^3v2r^2-54a^4v2r^2-2v2r^3-54a^2v2r^3)^2+ \\
& 4(-9a^2v2r(-a+v2r)-(-a+2a^2+v2r)^2)^3))^{1/3}) + \frac{1}{3 \cdot 2^{1/3}(-a+v2r)} \\
& (2a^3-12a^4+24a^5-16a^6-6a^2v2r+24a^3v2r-78a^4v2r+54a^5v2r+ \\
& 6av2r^2-12a^2v2r^2+108a^3v2r^2-54a^4v2r^2-2v2r^3-54a^2v2r^3+ \\
& \sqrt{((2a^3-12a^4+24a^5-16a^6-6a^2v2r+24a^3v2r-78a^4v2r+54a^5v2r+ \\
& 6av2r^2-12a^2v2r^2+108a^3v2r^2-54a^4v2r^2-2v2r^3-54a^2v2r^3)^2+ \\
& 4(-9a^2v2r(-a+v2r)-(-a+2a^2+v2r)^2)^3))^{1/3}}
\end{aligned} \tag{13}$$

Сая үзсэн диэлектрик ба өөрөө цуглуулагч керр орчин хоёрын зааг хавтгайг дагах гадаргуун соронзон долгио шугаман аналоггүй юм. Хэрвээ бид хоёр өөр шугаман орчны зааг авч үзсэнсэн бол (7) ийн оронд

$$v2r = \frac{a}{1+a} = \frac{\varepsilon_1}{\varepsilon + \varepsilon_1} \tag{14}$$

гарах байлаа. Энэ дүн бас (7)-д $x_0 = 1$ гэж тавихад гарч ирнэ. (14) аас харахад хэрвээ $\varepsilon_1 > 0$ бол гадаргуун соронзон долгио үүсэх $v2r > 1$ нөхцөл яав ч биелэхгүй.

Харин $a = \varepsilon_1 / \varepsilon < -1$ бөгөөд $\varepsilon_1 < 0$ байваас ($z < 0$) суурь орчины хувьд $v2r > 1$ нөхцөл хангагдах нь тодорхой байна. Энэ нь метал-диэлектрик зааг $a < -1$ тохиолд гадаргуун соронзон долгиог дэмждэг гэсэн үг. Үүнийг лавшруулан бид металл-өөрөө цуглуулагч керр орчин заагийн тохиолд гадаргуун соронзон долгио байх боломжийг шинжилэв.

$\beta^2 > \varepsilon_1$ нөхцөл триваль биелэгдэнэ, яагаад гэвэл, $\varepsilon_1 < 0$. Бас $a = \varepsilon_1 / \varepsilon < -1$ байхад (7) ба (9) илэрхийлүүд

$$1 < v2r, \quad 1 < x_0 < \theta r$$

нөхцөлүүдтэй нийцэхийн тулд $x_0 \in (1, \theta r)$ байвал зохино, үүнд θr нь (7) илэрхийллийн полюс, түүнийг бас (10) томъёогоор бодож тодорхойлно. Хэрвээ $v2r$ -г x_0 оос функц гэх юм бол $(1, \theta r)$ интервал дээр $a/(1+a)$ утгаас эхлэн хязгааргүй болтлоо монотонно өснө. Иймээс $a = \varepsilon_1 / \varepsilon < -1$ тохиолд β^2 ийн

$a/(1+a)$ аас их утгад гадаргуун долгионы бодлого цорын ганц шийдтэй. Үүнд (4) шийдэд $z_0 = 0$ зааг хавтгай дээрх диэлектрикийн функцийг ϵ_0 утгыг (12) томъёогоор тодорхойлж бас $\cos \Delta\Phi = -1$ гэж тавих хэрэгтэй. (4) шийдээр илэрхийлэгдэж буй өөрөө цуглуулагч керр орчинд асимптот бөхөх соронзон долгио нь $1R$ горимоор явагдах болно.

IV. ДОТООД БҮРЭН ОЙЛТ

Асимптот бөхөх соронзон долгио шийдийг бас дотоод бүрэн ойлтын бодлогод хэрэглэж болно. ε_1 диэлектрикийн тогтмолтой ($z > 0$) орчиноос гэрлийн соронзон хавтгай долгио ($z < 0$) өөрөө цуглуулагч керр орчны ($z = 0+$) хавтгай гадаргуу дээр тусч ойж байгаа гэж төсөөлөн бодъё. Энэ тохиолд рефракцийн тогмолын квадрат β^2 тусгалын өнцөг ϑ хоёр хоорондоо $\beta^2 = \varepsilon_1 \sin^2 \vartheta$, гэж холбогдоно.

Шугаман орчинд орон нь туссан ба ойсон долгио тус бүрийн орны нийлбэртэй тэнцүү тул $z = 0+$ дээр соронзон орны у компонент:

$$H_{1,y,tot} = H_{1,y}(1+r),$$

үүнд, $H_{1,y}$ -туссан долгионы соронзон орны у-компонент, r – ойлтын фактор.

$z = 0+$ дээр цахилгаан орны х компонентыг Максвеллийн тэгшитгэл хэрэглэн тодорхойлбол

$$E_{1,x,tot} = (r-1)\sqrt{1/\varepsilon_1} \cos \vartheta H_{1,y}$$

$z = 0 \pm$ дээр H_y / E_x харьцаа тасралтгүй байх нөхцөл:

$$\frac{1+r}{r-1} \frac{\sqrt{\varepsilon_1}}{\cos \vartheta} = \frac{h \exp(i\Phi_e)}{iA \exp(i\Phi_A)} \quad (15)$$

Дотоод бүрэн ойлтын тохиолд $r = \exp(i\sigma)$, σ - өнцөг туйлширлын өөрчлөлтийг тусгана. (15) аас

$$\Delta\Phi = \Phi_e - \Phi_A, \quad \sin \Delta\Phi = 0, \quad \text{буюу} \quad \cos \Delta\Phi = \pm 1 \quad (16)$$

$$\operatorname{tg} \frac{\sigma}{2} = \sqrt{\varepsilon_1} \frac{1}{\cos \vartheta} \frac{h}{A} \cos \Delta\Phi \quad (17)$$

$\cos \Delta\Phi = \pm 1$ ийн тэмдгийн сонголтоос σ өнцгийн тэмдэг төдийгүй ($z < 0$) өөрөө цуглуулагч керр орчинд асимптот бөхөх долгио тарах горим хамаарна. A^2 ба h^2 ийн (1) илэрхийлэлүүд ашиглан $\operatorname{tg}^2 \frac{\sigma}{2}$ -ийг

диэлектрикийн функцийн $z = 0$ - зааг хавтгай дээрх ϵ_0 утгаар илэрхийлбэл

$$\operatorname{tg}^2 \frac{\sigma}{2} = \frac{-\varepsilon\beta^2 + (3\beta^2 - 2\epsilon_0)\epsilon_0}{\epsilon_0^2(\varepsilon + \epsilon_0)} \frac{\varepsilon_1^2}{\varepsilon_1 - \beta^2} \quad (18)$$

Зааг хавтгай дээр туссан энергийн урсгал (хэмжээсгүй)

$$s = \frac{1}{8} (\varepsilon_1 A^2 + h^2 \frac{\varepsilon_1 - \beta^2}{\varepsilon_1}) \frac{1}{\sqrt{\varepsilon_1 - \beta^2}}$$

Үүнийг $z = 0$ - зааг хавтгай дээрх диэлектрикийн функцийн ϵ_0 утгаар илэрхийлбэл

$$s = \frac{(\varepsilon - \epsilon_0)(\varepsilon(-\varepsilon_1^2\beta^2 + \epsilon_0^2(\varepsilon_1 - \beta^2)) + \epsilon_0(\varepsilon_1^2(3\beta^2 - 2\epsilon_0) + \epsilon_0^2(\varepsilon_1 - \beta^2)))}{16\varepsilon_1\epsilon_0(-2\beta^2 + \epsilon_0)\sqrt{\varepsilon_1 - \beta^2}} \quad (19)$$

$\operatorname{tg} \frac{\sigma}{2} = -\sqrt{\operatorname{tg}^2 \frac{\sigma}{2}} \cos \Delta\Phi$ ба s хоёулаа нэгэн ϵ_0 хэмжигдүүнээр илэрхийлэгдэж байгаа болохлоор дотоод бүрэн ойлт зааг хавтгай дээр туссан энергийн урсгалаас хамаардаг гэсэн үг. Энэ хамаарал заримдаа нэгэн утгатай биш байдаг, энэ нь ижилхэн хэмжээтэй энергийн урсгал өөр, өөр ойлт өдөөх боломжтой гэсэн хэрэг. Үүнийг гайхаад байх хэрэггүй, учир нь гэвэл, иймэрхүү гистерезисийн үзэгдэл шугаман биш динамикт элбэг тохиолддог юм. Жишээ болгож $\varepsilon_1 = 3.01$, $\varepsilon = 2.5$, $\beta^2 = 2.95$, $\cos \Delta\Phi = -1$ тохиолд дотоод бүрэн ойлт зааг хавтгай дээр туссан энергийн урсгалаас хамаарах хамаарлыг график 5-д үзүүлэв.




График 5. Муруй шугам сүүл хэсэгтээ хоёр утгат холбоог илэрхийлж байна. Хэрвээ бүр анхнаасаа $\cos \Delta\Phi = +1$ гэж сонгосон бол энэ графикт зөвхөн σ өнцгийн тэмдэг л өөр байх байсан.

ТАЛАРХАЛ

Энэхүү ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж суурь судалгааны SSA_017/2016 төслийг санхүүжүүлсэн ШУТС болон БСШУСЯ талархал илэрхийлье. Гэрэл бодисын харилцан үйлчлэл сэдвийн хүрээнд явуулдаг манай судалгаанд ач холбогдол өгч дэмжиж тусалсаар ирсэн проф. Ж.Даваасамбууд баярлалаа гэж хэлье, эрдмийн ажилд нь их амжилт хүсье.

НОМЗҮЙ

- [1] Г.Очирбат, О. Нямсүрэн. Өөрөө цуглуулагч керр орчин дахь гэрлийн стационар ТМ асимптот босоо долгио МУИС, ЭШБ 2006 №282(14) 80-81.
- [2] Г.Очирбат, О. Нямсүрэн. Өөрөө цуглуулагч керр орчин дахь гэрлийн стационар ТМ долгионы оронд диэлектрикийн функц параметруудаас хамаарах нь МУИС, ЭШБ 2006 №282(14) 64-73.
- [3] О. Нямсүрэн, Г.Очирбат. Гэрлийн стационар соронзон босоо долгио. Товчоо МУИС, ЭШБ 2009 №309(15) 122-125.

Максвеллийн тэгшитгэлийн, өөрөө сарниулагч оптик керр орчинд асимптот бөхөх гэрлийн соронзон долгио шийд. Түүний зарим хялбар хэрэглээ.

Г.Очирбат^{1*}, О.Нямсүрэн², Д.Улам-Оргих¹

¹ Физикийн тэнхим, Шинжлэх ухааны сургууль, МУИС

² Шинэ Монгол Технологийн дээд сургууль

I. УДИРТГАЛ

Оптик холбооны багаж бүтээх зорилттой холбогдулан шугаман биш үе бүхий долгио хөтлөгчөөр гэрлийн долгио тарах асуудлыг судлаачид аль эртнээс сонирхсоор иржээ. Бид харин шугаман биш үе буюу илтсээр гэрлийн соронзон ба цахилгаан долгио тарах бодлого бодоход зориулан нилээд өвөрмөгц арга зүй боловсруулсан билээ[1-3].

Хавтгай дээр татсан тэнхлэг дагуу хавтгай долгио мэт, харин хавтгайд ортогональ тэнхлэгийн координатаас триваль биш хамааралтай соронзон долгионы оронг дараах хэлбэртэй дүрсэлдэг

$$E_x = iAe^{i\Phi_A}\varphi, \quad E_z = e e^{i\Phi_e}\varphi, \quad H_y = h e^{i\Phi_h}\varphi, \quad \varphi = \exp(-i\omega t + k_0\beta x)$$

Үүнд $A > 0, e > 0, h < 0, k_0 = \omega/c, \beta$ – рефракцийн тогтмол.

Соронзон долгионы орон дахь өөрөө сарниулагч оптик керр орчины диэлектрикийн функц

$$\epsilon = \epsilon - A^2 - e^2$$

Үүнд ϵ -диэлектрикийн тогтмол. Бид максвеллийн тэгшитгэлийг бодохдоо юуны урьд түүний хоёр анхны интегралыг ашиглан диэлектрикийн функц координатаас хамаарах хамаарлыг олох зорилго тавьдаг; оронгийн амплитуд бүр диэлектрикийн функцээр илэрхийлэгддэг тул энэ нь соронзон долгионы оронг зураглах нэгэн өвөрмөгц хувилбар болж чаддаг.

Оронгийн амплитуд бүр диэлектрикийн функцээр дараах хэлбэртэй илэрхийлэгддэг

$$h^2 = \frac{e}{2\beta^2 - e} \frac{\epsilon^2 - e^2 - 2cnst}{2}, \quad A^2 = \epsilon - e - \frac{\beta^2}{e^2} h^2, \quad (1)$$

$$e^2 = \frac{\beta^2}{2\beta^2 - e} \frac{\epsilon^2 - e^2 - 2cnst}{2e}$$

Диэлектрикийн функцээс координатаар авсан уламжлал

$$\frac{de}{dz} = \frac{(2\beta^2 - e)}{e/2 - e^2} Ah \cos \Delta\Phi, \quad \text{где } \Delta\Phi = \Phi_e - \Phi_A \quad (2)$$

Энергийн урсгал хадгалагдах хууль

$$\frac{1}{2} Ah \sin \Delta\Phi = c0 \quad (3)$$

(1), (3) ийн тусламжтайгаар (2) нь диэлектрикийн функц координатаас хамаарах хамаарлыг тодорхойлох тэгшитгэл болж хувирна. Энэ хамаарал нь

$$z - z_0 = \int_{e_0}^e \frac{(\frac{e}{2} - e^2) de}{(2\beta^2 - e) Ah \cos \Delta\Phi} \quad (4)$$

Бид энэ битүүлэг квадратур шийдийг $\beta^2, 2cnst, c0$ гурван параметраас хамааруулан дэлгэрэнгүй шинжилсэн[1-2].

II. АСИМПТОТ БӨХӨХ СОРОНЗОН ДОЛГИО ШИЙД

(1) ийг ажиглахад, $e \rightarrow \epsilon$ хязгаарт $A^2 \rightarrow 0, h^2 \rightarrow 0$ болохын тулд $2cnst = 0$ байх нь мэдэгдэнэ. Бас (3) аас харахад $c0 = 0$ болохын тулд

$$\sin \Delta\Phi = 0 \quad \text{буюу} \quad \cos \Delta\Phi = \pm 1 \quad (5)$$

(1) илэрхийллүүдийг шинжилж үзэхэд, $A^2 \geq 0 \& h^2 \geq 0$ нөхцөлд $e \rightarrow \epsilon$ хязгаарт үүсэх боломж зөвхөн $\beta^2 \geq \epsilon$ тохиолд e хэмжигдүүн $[\theta, \epsilon]$ завсарт тодорхойлогдсон байхад л гарч ирдэг. Үүнд

$$\theta = \frac{3}{4} \beta^2 - \sqrt{\frac{9}{16} \beta^4 - 0.5 \beta^2 \epsilon} \quad (6)$$

$[\theta, \epsilon]$ завсрын дээд хил болох ϵ цэг нь $A^2 h^2$ функцийн хоёрдугаар эрэмбийн тэг цэг, харин доод хил болох θ цэг нь нэгдүгээр эрэмбийн тэг цэг мөн гэдгийг цохон тэмдэглэе.

Энд өөрөө цуглуулагч керр орчноос ялгарах нэг онцлог нь гэвэл анхны утгын бодлогын (4)

* Electronic address:

шийдэд интеграндын хүртвэрд буй $e/2 - e^2$ илэрхийлэл e -ээс хамааран хувьсахдаа нэгэн цэг дээр тэмдэгээ өөрчилдөг, тэр нэгэн цэг нь: $e = \xi$, $\xi \in (\theta, \varepsilon)$, үүнд

$$\xi = \beta^2 - \frac{(1-i\sqrt{3})\beta^4}{2^{2/3}(-\varepsilon^2\beta^2 + 2\beta^6 + \sqrt{\varepsilon^4\beta^4 - 4\varepsilon^2\beta^8})^{1/3}} - \frac{(1+i\sqrt{3})(-\varepsilon^2\beta^2 + 2\beta^6 + \sqrt{\varepsilon^4\beta^4 - 4\varepsilon^2\beta^8})^{1/3}}{22^{1/3}} \quad (7)$$

$e/2 - e^2$ функц яаж хувьсдагийг график 1-с мэдэрч болно.




График 1. $e/2 - e^2$ функцийн график. $\varepsilon = 2.6$, $\beta^2 = 2.95$. Тооцоогоор олсон нь: $\theta = 1.18286$, $\xi = 1.66611$. Энэ функц $[\theta, \varepsilon]$ завсрын дээд хил болох $e = \varepsilon$ цэг дээр эерэг, доод хил болох $e = \theta$ цэг дээр сөрөг утга аваад харин $e = \xi$ цэг дээр тэмдэгээ өөрчилжээ.

$e/2 - e^2$ -ийн энэ шинжээс шалтгаалан (4)-ээр тодорхойлогдох $\epsilon(z)$ функц $z - z_0 \rightarrow \pm\infty$ хязгаарт $e \rightarrow \varepsilon$ хязгаард шилжихийн өмнө анхны утга e_0 бас $\cos \Delta\Phi = \pm 1$ ийн тэмдгийн сонголтоос хамаарч эргэж буцсан төвөгтэй хэлбэрийг олох боломжтой. Үүнийг график 2-с харж болно.




График 2. $\epsilon(z)$ функцийн графикийг $e_0 > \xi$ ба $\cos \Delta\Phi = -1$ тохиолд зуржээ. $\beta^2 = 2.95$, $\varepsilon = 2.6$.

Тооцоогоор олсон нь: $\theta = 1.18286$, $\xi = 1.66611$. Сонгосон анхны утга: $(z_0, e_0) = (0., 2.29067)$ Харваас, OZ тэнхлэгийн сөрөг чиглэлд анхны утга e_0 ээс эхлэн буурчбайсан $\epsilon(z)$ функц явц дундаа хэдэн удаа эргэн гогцоорсны эцэст $z \rightarrow -\infty$ хязгаарт ε утга руу тэмүүлжээ.

$\epsilon(z)$ функц зөвхөн $e_0 > \xi$ ба $\cos \Delta\Phi = +1$ тохиолд л монотонно өссөөр $z \rightarrow -\infty$ хязгаарт ε утга руугаа тэмүүлнэ, график 3-с харна уу.




График 3. $\epsilon(z)$: функцийн графикийг $e_0 > \xi$ ба $\cos \Delta\Phi = +1$ тохиолд зуржээ. Тооцоогоор олсон нь: $\theta = 1.18286$, $\xi = 1.66611$. Сонгосон анхны утга: $(z_0, e_0) = (0., 1.76611)$. Харваас, $\epsilon(z)$ функц, OZ тэнхлэгийн сөрөг чиглэлд, e_0 анхны утгаасаа эхлэн бууран буурсаар ε утга руу гаа тэмүүлжээ.

Ш. ГАДАРГУУН СОРОНЗОН ДОЛГИО

Өөрөө сарниулагч керр орчинд асимптот бөхөх долгио шийдийг гадаргун соронзон долгионы бодлогод хэрэглэх асуудал тийм ч ойлгомжтой зүйл биш бололтой. (график 2-т үзүүлсэн шиг) эргэж гогцоорсон муруйгаар дүрслэгдэх функц хэлбэртэй шийд заагийн нөхцөлтэй авцалдах боломж харагдахгүй байна. Харин $z_0 = 0$ - зааг хавтгай дээрх диэлектрикийн функцийн утга e_0 нь $e/2 - e^2$ ийн тэмдэгээ хувиргах $e = \xi$ цэгийн баруун талд оршихын ($e_0 > \xi$) дээр бас $\cos \Delta\Phi = +1$ байх (график 3-т үзүүлсэн шиг) тохиолд л ($z < 0$) өөрөө сарниулагч керр орчинд асимптот бөхөх соронзон долгио шийдийн тухай ярьж болмоор. ε_1 диэлектрикийн тогтмолтой ($z > 0$) шугаман диэлектрик орчин ε диэлектрикийн тогтмолтой ($z < 0$) өөрөө сарниулагч керр орчин хоёрын ($z = 0$) зааг хавтгай дагуу тарах гэрлийн соронзон долгио байж болох бүх боломжийг хоёр орчны диэлектрикийн тогтмол ба рефракцийн тогтмол β эдгээр гурван параметраас хамааруулан илрүүлэн гаргахыг хичээе. Энэ зорилгын үүднээс диэлектрикийн функц ($z = 0$) зааг хавтгай

дээрх ϵ_0 утгаасаа эхлэн ($z < 0$) өөрөө сарниулагч керр орчны гүн тийш хувьсахдаа яваандаа ϵ утга руу тэмүүлэх боломжийг судлая. Шугаман орчинд $z \rightarrow \infty$ хязгаарт бөхөх соронзон долгио байх нөхцөл нь $\epsilon_1 < \beta^2$ мөн гэдгийг юуны урьд тэмдэглэе.

Заагийн нөхцөл ашиглахад ϵ_1, ϵ , β^2 параметрууд ба зааг хавтгай дээрх сарниулагч керр орчны диэлектрикийн функцийг утга ϵ_0 эдгээр дөрвөн хэмжигдүүнээр интегралчлалын тогтмол илэрхийлэгдэнэ.

$$2cnst = \epsilon^2 - \epsilon_0^2 + \frac{2(2\beta^2 - \epsilon_0)(\epsilon_0 - \epsilon)}{\epsilon_0((- \epsilon_1 + \beta^2)/\epsilon_1^2 + \beta^2/\epsilon_0^2)}$$

$2cnst = 0$ гэж эндээс β^2 г бусад хэмжигдүүнээр нь илэрхийлбэл

$$\beta^2 = \frac{\epsilon_1 \epsilon_0^2 (\epsilon - 2\epsilon_1 + \epsilon_0)}{-3\epsilon_1^2 \epsilon_0 + \epsilon_0^3 + \epsilon(\epsilon_1^2 + \epsilon_0^2)} \quad (8)'$$

Хэрвээ

$$x_0 = \epsilon_0 / \epsilon, \quad a = \epsilon_1 / \epsilon, \quad v2r = \beta^2 / \epsilon, \quad \theta r = \theta / \epsilon \quad \xi r = \xi / \epsilon \quad (9)$$

гэж тэмдэглэвэл (8)' нь

$$v2r = \frac{ax_0^2(1 - 2a + x_0)}{-3a^2x_0 + x_0^3 + (a^2 + x_0^2)} \quad (8)$$

Мөн түүнчилэн

$$\epsilon_1 < \beta^2, \quad \epsilon < \beta^2, \quad \theta < \xi < \epsilon_0 < \epsilon \quad (10)'$$

гэсэн бөхөх соронзон долгио байх нөхцөлүүд нь $a < v2r$, $\theta r < \xi r < x_0 < 1 < v2r$ (10)

- хэлбэртэй бичигдэнэ. Үүнд

$$\theta r = \frac{3}{4} v2r - \sqrt{\frac{9}{16} v2r^2 - 0.5 v2r} \quad (11)$$

Тэгэхлээр одоо ϵ_1, ϵ , β^2 параметрууд ын өгөгдсөн утгад (10) нөхцөлүүдтэй нийцэх, диэлектрик ийн функцийг, зааг хавтгай дээрх x_0 утга олдохуу, олдвол эдгээр параметраар яаж тодорхойлогдох вэ гэсэн асуултанд хариулах л үлдлээ.

Шинжилгээнд ξ ийг β^2 ээр илэрхийлсэн (7) илэрхийлэлийн оронд $v2r$ ийг ξr ээр илэрхийлсэн дараах илэрхийлэл

$$v2r = \frac{\xi r^3}{2\xi r^2 - 1} \quad (12)$$

-ашиглах нь дөхөмтэй. Тухайлбал, эндээс $v2r > 1$ нөхцөл хангахын тулд

$$\xi r \in (1/\sqrt{3}, \xi_0), \quad \xi_0 = .652704 < 2/3$$

гэж мэдэгдэнэ. Цаашилбал ийм ξr утгуудад $\theta r \leq \xi r$ нөхцөл хангагдана гэдгийг мэдэхэд төвөггүй. Тухайлбал, (12) ийн улмаас θr -г ξr ээс хамаарсан функц мэтээр авч үзэж болох бөгөөд ингэхэд $\theta r \leq \xi r$ тэнцэл бусыг шууд шалгах боломж гарна. График 4-с үзнэ үү.




